



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 оны 01 дүгээр сарын 09  
№01 (1346)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠯᠢᠨ  
ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |     |  |           |   |
|-----|--|-----------|---|
| 01. | Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч<br>бус гишүүнээр томилох тухай   | Дугаар 56 | 3 |
| 02. | Үндсэн хуулийн цэцийн 2024 оны<br>04 дүгээр дүгнэлтийн тухай   | Дугаар 57 | 5 |
| 03. | Монгол Улсын Засгийн газар, Бүгд<br>Найрамдах Хятад Ард Улсын Засгийн<br>газар хооронд Гашуунсухайт-Ганцмод<br>боомтын хил дамнасан төмөр замын бүтээн<br>байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг<br>байгуулахад баримтлах үндсэн чиглэл<br>батлах тухай | Дугаар 58 | 7 |

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- |     |   |           |    |
|-----|---|-----------|----|
| 04. | Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн<br>13.4 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3 дахь<br>заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх<br>маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 04 | 13 |
|-----|---|-----------|----|

<b>ՆԱԽԿԱՏՐ</b>	
3	<p>05. Երևանի մարզի Կոմիտասի անվան համալսարանի Կրթության և գիտության համակարգի մասին օրենսդրության մասին</p> <p>06. Կրթության մասին օրենսդրության մասին</p>
4	<p>05. Կրթության մասին օրենսդրության մասին</p> <p>06. Կրթության մասին օրենսդրության մասին</p>
5	<p>05. Կրթության մասին օրենսդրության մասին</p> <p>06. Կրթության մասին օրենսդրության մասին</p>
6	<p>05. Կրթության մասին օրենսդրության մասին</p> <p>06. Կրթության մասին օրենսդրության մասին</p>

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар  
хот

### **Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох тухай**

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2, 76.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Самдангийн Энхбаатарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 57

Улаанбаатар  
хот

### **Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан ... татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ... Иргэний хувийн ... халдашгүй байдлыг хуулиар хамгаална;” гэж заасныг зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар  
хот

**Монгол Улсын Засгийн газар, Бүгд  
Найрамдах Хятад Ард Улсын Засгийн  
газар хооронд Гашуунсухайт-Ганцмод  
боомтын хил дамнасан төмөр замын  
бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх  
хэлэлцээрийг байгуулахад баримтлах  
үндсэн чиглэл батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т заасан Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд хэлэлцээр байгуулах чиглэлээр хэлэлцээ хийхэд дараах үндсэн чиглэлийг баримталж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т зөвшөөрсүгэй:

1/Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд төрийн дээд, өндөр түвшинд тохирсон иж бүрэн хамтын ажиллагааны хүрээнд аливаа гуравдагч талын оролцоогүйгээр хэрэгжүүлэх;

2/Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн өгөөжийг хангах зорилгоор төмөр замын бүтээн байгуулалт, нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээг байгуулах, уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гурван асуудлыг харилцан уялдаатай цогц байдлаар хамтад нь шийдвэрлэх;

3/Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа, эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусад этгээдэд шилжүүлэхгүй байх;



4/Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн багтаамж, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний үнийг тогтоохдоо “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн урт хугацаатай байгуулсан гэрээний нөхцөл, үнийн аргачлалыг жишиг болгож, гэрээний хугацааг хэлэлцээ хийж эхэлсэн хугацаатай уялдуулан 16 хүртэл жилээр тогтоох;

5/Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу нийлүүлэх нүүрсний хэмжээг 2025-2029 онд нийт 27 сая тонн, 2030 оноос эхлэн жилд 20 сая тонноос бууруулахгүй, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхайн олборлолтын төлөвлөгөөтэй нийцүүлэн коксжих, сул коксжих, эрчим хүчний нүүрсийг зохимжит хувь харьцаагаар нийлүүлэх буюу зөвхөн нэг төрлийн нүүрсийг сорчлохгүй байх;

6/Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замыг байгуулахад өргөн, нарийн царигийн аливаа маргаан дахин үүсэхгүйг бататгах;

7/Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтад “Нэг зураг төсөлтэй, нэг гүйцэтгэгчтэй, бүтээн байгуулалтыг зэрэг эхлүүлж, зэрэг дуусгах” зарчим баримтлах;

8/Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам барих, түүнийг холбох бүтээн байгуулалтын төслийн ажлыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талын сонгон шалгаруулсан аж ахуйн нэгжээр төмөр зам, түүнийг холбох барилга байгууламжийг гүйцэтгүүлэн хамтран ажиллах;

9/Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил доторх Ганцмод боомт хүртэл баригдсан төмөр замын бүтээн байгуулалттай холбогдуулж өнгөрсөн хугацаанд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд гарсан аливаа алдагдал, хохирол болон төмөр замын хил холболтод шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг ирээдүйд нэхэмжлүүлэхгүй байх;

10/Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлснээр Монгол, Хятадын хилийн Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхатавч зэрэг боомтыг төмөр замаар холбох ажлыг үе шаттайгаар эхлүүлэх тохиролцоонд хүрэх;



11/Байтаг-Улиастайн боомтыг байнгын үйл ажиллагаатай болгох, Булган-Такашикен боомтод улсын хилийн 126, 127 дугаар тэмдгийн хооронд автозамаар улсын хилийн шугамыг дайран өнгөрөх цэгийг тохирч, хилийн гарц шинээр нэмэх, нүүрс ачиж буулгах талбай, ачаа тээврийн терминал болон улсын хил дамнасан автозамын бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар эхлүүлэх талаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай тохиролцох;

12/сэргээгдэх эрчим хүчний экспорт, эрчим хүчний нүүрс экспортлох, нүүрсийг гүн боловсруулах аж үйлдвэржилт, говийг усжуулах, шар шороон шуурга, цөлжилттэй тэмцэх, хил холболт болон дэд бүтцийн бүтээн байгуулалт, орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутагт ажлын байр шинээр бий болгох, орон сууцжуулалтын асуудалд харилцан ашигтай хувилбарт шийдэл бүхий нөхцөлөөр хамтран ажиллах.

2.Энэ тогтоолыг хэрэгжүүлэхдээ Засгийн газар хоорондын хэлэлцээр, Ажлын хэсгүүд хоорондын албан ёсны хэлэлцээний протокол, аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагааны гэрээнүүд байгуулах, шаардлагатай бол эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор хууль тогтоомжийн төсөл санаачлах чиглэлээр ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо /Г.Тэмүүлэн/, Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**









## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2024 оны 11 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар  
хот

### **Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны  
танхим 15.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар /Илтгэгч/, О.Мөнхсайхан, Э.Энхтуяа нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн П.Эрхэмбаяр, мэдээлэл гаргагчийн өмгөөлөгч Д.Болд-Эрдэнэ, Н.Түмэнбаяр болон мэргэжилтнээр Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар оролцлоо.

Мэдээлэл гаргагч иргэн Ч.Лодойсамбуу, Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нар хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй болсон тул эзгүйд нь маргааныг хянан шийдвэрлэхийг зөвшөөрсөн хүсэлтийг ирүүлсэн болно.

Энэхүү хуралдаанаар Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. ... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;” гэж заасныг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

***Нэг. Монгол Улсын иргэн П.Эрхэмбаяр, Ч.Лодойсамбуу нар Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлжээ:***



“... Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно.” мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсэгт “Арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон бусад санхүүгийн эрх бүхий байгууллага дараах мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ.” гээд 34.4.1 дэх заалтад “татвар төлөгчийн дансны мэдээлэл болон уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээллийг татварын албаны шаардсанаар тухай бүр;”, 34.4.3 дахь заалтад “татвар төлөгчийн дансны гүйлгээний мэдээллийг татварын албанаас бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг үндэслэн.” (хуралдааны эхэнд тус заалтад оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу шаардлагаа ийнхүү өөрчилж байгаагаа илэрхийлсэн) гэж тус тус заасан байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. ... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;” гэж заасныг зөрчиж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх жам ёсны эрх, эрх чөлөөг тусгаж, Нэгдсэн Үндэстний Байгууллага болон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлж хүний жам ёсны эрх нь ямар ч эрх мэдлийн дээр гэдгийг батлан тунхагласан юм. Ийм учраас хүний эрх, эрх чөлөөг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйл болон үндэстний эрх зүйн хэм хэмжээгээр тодорхойлохгүй бөгөөд олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн нийтлэг ойлголт юм.

Төрөөс хууль баталж хүний жам ёсны эрх, эрх чөлөөнд халдах мөнхийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд хязгаарлаж чадсан зохицуулалт бол Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад заасан хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх юм. Уг эрхийг тунхагласан нь Монгол Улсын Үндсэн хуулийн үнэ цэн билээ. Хүн эрх чөлөөтэй, түүний бие махбод, нэр төр, орон байр, хувийн нууц, мэдээлэл, емч хөрөнгө халдашгүй дархан байх эрхийг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаатай олгожээ. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг анх 1215 онд Магна Хартын 39 дүгээр зүйлд “Шүүхийн шийдвэрт, эсвэл газрын тухай хуульд зааснаас бусад тохиолдолд ямар ч чөлөөт иргэний баривчлах, хорих, эрх болон эзэмшлийг нь хязгаарлах, эсхүл бусад аргаар түүний эрх зүйн байдлыг дордуулах, хөөхгүй ба түүний эсрэг хүч хэрэглэх, эсхүл бусдаар хүч хэрэглүүлж болохгүй” гэж тусгаж байсан. Мөн хууль, шүүхийн



шийдвэргүйгээр хүний эрх, эрх чөлөөнд халдах, хүч хэрэглэхийг хориглох замаар хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалж байжээ.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 3 дугаар зүйлд “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй.”, 12 дугаар зүйлд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. ...”; Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй.” гэж Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод заажээ.

Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно гэсэн агуулгын хамгийн гол анхаарах зүйл бол “хуульд заасан үндэслэл, журам”, “дур мэдэн” гэсэн нөхцөл заасан хэсэг юм. “Дур мэдэн” гэдэг нь хууль бус үйлдлийг хэлэхээс гадна хүч, нөлөөллийг хэтрүүлсэн, шударга бус үйлдлийг ойлгоно. “Хуульд заасан үндэслэл, журам” гэдэг нөхцөлийг хууль тогтоогчийн үзэмжээр буюу хууль л бол хууль гэсэн утгаар ойлгож болохгүй. Халдашгүй, чөлөөтэй байх үндсэн эрх бол хүн болж төрсний хамгийн үнэ цэнтэй амьдрах, амьд явах эрхийн үндсэн баталгаа учраас түүнийг хууль тогтоогчийн гарт зүгээр орхидоггүй. Өөрөөр хэлбэл, хууль тогтоогч хуулиар дамжуулан хүний жам ёсны эрхийг зөрчиж байвал “эрх зүйд захирагдах ёс (rule of law)”, “эрх зүйн шударга процессын зарчим (due process of law)”-д тулгуурласан эсэхийг заавал нягтлах шаардлагатай. Хэрэв энэ хоёр зарчимд тулгуурлаагүй хуулийг баримтлан нэгжлэг хийж, баривчилж, мөрдөн мөшгийж, эрх чөлөөг нь хязгаарласан бол “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур” буюу Үндсэн хуулийн зөрчил болно.

Нэгжих гэдгийг Монгол хэлний их тайлбар тольд “хууль бус эд хөрөнгө, бичиг данс зэрэг зүйл нуусныг эрж олохоор тусгайлан хайх, байцаах, нэгжин үзэх ...” гэсэн агуулгаар тайлбарласан байна. Г.Совд, Н.Жанцан, Ж.Амарсанаа, С.Жанцан нарын “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар” номд “Нэгжих гэдэг бол гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэхэд ач холбогдол бүхий эд зүйл, баримт бичиг, багаж зэвсэг зэрэг нотлох баримтын зүйлийг эрж олохын тулд бусдын бие, хувцас, орон байр, агуулах, авдар саванд халдах ажиллагааг хэлдэг.” гэсэн байна. Өөрөөр хэлбэл, эрүүгийн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэлд хүний халдашгүй, чөлөөтэй байх онцгой суурь эрхэнд “эрх зүйн шударга процессын зарчим”-ыг үндэслэн шүүх, прокурорын зөвшөөрлөөр нэгжих ёстой байтал татварын байцаагч нэг албан хүсэлтээр хүний дансыг нэгжиж байгаа нь Үндсэн хууль зөрчиж байна. ...” гэжээ.



**Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:**

“... 1.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх үндсэн үүргийг ёсчлон биелүүлэхээр заасан. Улмаар Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.3 дахь заалтад татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хяналт шалгалт хийх зэрэг үйл ажиллагаанд зайлшгүй байх, шударга байх зарчмыг баримтлахаар заасан байдаг.

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө.” гэж заасан байдаг боловч Монгол Улсын Үндсэн хуульд заасан шударга ёсыг эрхэмлэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх үндсэн үүргээ ёсчлон биелүүлэхгүй татвараас зайлсхийх, зугтаах зөрчлүүд гарч байдаг. Иймээс татвар зайлшгүй байх, шударга байх Монгол Улсын Үндсэн хууль, Татварын ерөнхий хуульд заасан зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор татварын хууль тогтоомжоор татварын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж, татвар төлөгчийн эрсдэлийг тооцох, энэхүү эрсдэлд үндэслэн хяналт шалгалт хийх, татвараас зайлсхийх, зугтаах явдлаас урьдчилан сэргийлэх, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэг чиг үүргээ татварын алба хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлдэг.

Татварын бүртгэл, ногдуулалтын үйл ажиллагаа нь нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, бүртгэл, гүйлгээ, дансны мэдээлэлд үндэслэн хийгддэг бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд заасан шударга ёсыг эрхэмлэн хуулиар ногдуулсан татварыг төлөх үндсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавихад татварын албаны зүгээс хууль тогтоомжийн хүрээнд холбогдох мэдээ, мэдээлэл, баримт материалыг гаргуулан авах нь зүй ёсны асуудал юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад Монгол Улсын иргэн халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй гэж заасан боловч энэ эрхээ хэрэгжүүлэхдээ тус хуульд заасан үндсэн үүргээ хэрэгжүүлэхгүй байх үндэслэл болохгүй юм. Улмаар татварын байгууллагын зүгээс хуульд заасан үндэслэлээр татвар төлөгчийн дансны мэдээлэл, уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээлэл, татвар төлөгчийн дансны гүйлгээний мэдээллийг холбогдох банк, санхүүгийн байгууллагаас авч хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад

“... Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ...” гэж заасантай нийцэж байгаа бөгөөд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хязгаарлахгүй юм. Түүнчлэн Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт татварын алба нь энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр татвар төлөгчийн мэдээллийг бусдад өгөх, эсхүл хувийн зорилгоор ашиглах байдлаар задруулахыг хориглохоор зааж татвар төлөгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хуулиар хамгаалсан болохыг онцлох нь зүйтэй байна.

2.Европын холбооноос 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Монгол Улсыг “Татварын зорилгоор ил тод байдал, мэдээлэл солилцооны Олон улсын форум”-ын гишүүн биш, Татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай олон талт конвенцод нэгдэн орж соёрхон батлаагүй гэсэн үндэслэлээр “Татварын зорилгоор хамтран ажилладаггүй улс орнуудын жагсаалт”-д оруулсан байдаг. Улмаар Монгол Улс “Татварын зорилгоор ил тод байдал, мэдээлэл солилцооны Олон улсын форум”-д гишүүнээр элсэж, холбогдох стандартыг мөрдөж ажиллах, олон талт конвенцод нэгдэн орох үүрэг амлалт өгснөөр 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр энэхүү жагсаалтаас гарч байсан билээ. “Татварын зорилгоор ил тод байдал, мэдээлэл солилцооны Олон улсын форум” нь олон улсын хэмжээнд татварын зорилгоор банк мэдээллээ нууцлах, мэдээлэл өгөхгүй байх явдлыг таслан зогсоон татварын ил тод байдлыг хангаж, татвараас зайлсхийх явдалтай хамтран тэмцэх зорилготой дэлхийн 165 улс орныг эгнээндээ нэгтгэсэн институц юм. Энэ байгууллагын гишүүн орнууд татварын зорилгоор банк, санхүүгийн байгууллагад байгаа татвар төлөгчдийн мэдээллийг харилцан солилцох дүрэм журмыг даган мөрдөх үүрэг хүлээдэг юм.

Улмаар Монгол Улс Олон улсын форумын гишүүн орны хувьд татварын ил тод байдлыг хангах, татварын зорилгоор банкны мэдээлэл авах, мэдээллийг харилцан солилцохтой холбоотой шаардлага, стандартыг Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйл, 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсэгт тусган хэрэгжүүлж байна. Түүнчлэн Европын холбооны өмнө хүлээсэн үүрэг амлалтаа хэрэгжүүлж татварын зорилгоор бусад улстай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, захиргааны туслалцаа харилцан үзүүлэх зорилго бүхий Татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай конвенцод Монгол Улс нэгдэн орж, Улсын Их Хурал 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр уг конвенцыг соёрхон батлах тухай хуулийг баталсан. Энэ конвенцын хэрэгжилтийг хангахын тулд татварын алба татвар төлөгчийн банк, санхүүгийн байгууллага дахь данс, данс эзэмшигч, дансны гүйлгээний мэдээллийг авах зайлшгүй шаардлагатай байдаг.



Татварын ерөнхий газар нь банкны мэдээллийг татварын албаны хөндлөнгийн мэдээллийн санд бүртгэж, зөвхөн Татварын ерөнхий газрын даргын эрх олгосон албан тушаалтан нь уг мэдээлэлтэй зохих журмын дагуу танилцаж, хадгалалт, хамгаалалтыг хариуцах эрх, үүрэгтэй байдаг. Харин татварын албаны хэмжээнд бүх албан хаагч мэдээллийг ашиглах болон харах эрхгүй юм.

Татварын ерөнхий хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдахаас сэргийлэх хүрээнд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Олон улсын 130 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, 130/1ЕС 27001:2013 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартыг хэрэгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын үүднээс эрхийн тохиргоо, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн журмыг баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд татварын алба нь арилжааны 11 банкттай “Мэдээлэл харилцан солилцох гэрээ”-г харилцан тохиролцож байгуулсан. Тус гэрээнд заасан арилжааны банкны хүлээх үүрэгт Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.2 дахь заалтад заасан мэдээллийг сар бүрийн 10-ны өдрийн дотор, мөн хуулийн 34.4.1 болон 34.4.2 дахь заалтад заасан мэдээллийг тухай бүр татварын албанаас албан бичгээр болон тоон гарын үсгээр баталгаажсан цахим хүсэлтийг үндэслэн цахим хэлбэрээр тус тус гаргаж өгөхөөр тодорхойлж тусгасан. Харин татварын алба нь банкнаас ирүүлсэн татвар төлөгчийн дансны мэдээллийг аливаа хэлбэрээр гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй байх, зөвхөн хуулийн хүрээнд татварын зорилгоор ашиглах үүрэг хүлээсэн. Түүнчлэн татварын алба нь арилжааны банкнаас татвар төлөгчийн дансны мэдээллийг хүлээн авахдаа техник, технологийн шаардлага хангасан мэдээллийн системийг бий болгох, цахим сангийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангасан байх үүрэгтэй. Гэрээний оролцогч талууд нь мэдээллийг чандлан хадгалах үүрэгтэй бөгөөд хууль болон гэрээнд зааснаас өөр зорилгоор ашиглах, гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр дамжуулахыг хатуу хориглож, мэдээллийн нууцлалыг хугацаагүйгээр хадгалах үүрэг хүлээн ажиллаж байна.

3.Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд зөрчлөө арилгахгүй байгаа, нэг зөрчлийг 3 ба түүнээс дээш удаа давтан гаргасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар тухайн татвар төлөгчийн зөвшөөрөлгүй нийтэд мэдээлж болох тухай заасан нь иргэний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг зөрчихгүй. Тус заалт нь 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан Татварын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт “Татварын хууль тогтоомжийг зөрчсөн нь нотлогдсон, эсхүл татвар



төлөхөөс зайлсхийсэн болон эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар татварын алба энэ хуулийн 14.4-т заасан зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно.” гэж тусгагдсан байсан зохицуулалт бөгөөд 17 дахь жилдээ үйлчилж байна. Энэхүү хуулийн зохицуулалт нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд зөрчлөө арилгахгүй байгаа, нэг зөрчлийг 3 ба түүнээс дээш удаа давтан гаргасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар тухайн татвар төлөгчийн зөвшөөрөлгүй нийтэд мэдээлж болох тухай заасан нь иргэний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг зөрчихгүй, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нөгөө талаас Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх үндсэн үүргийг ёсчлон биелүүлэхээр заасныг хэрэгжүүлэх ач холбогдолтой.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталсан Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.” гэсэн байна.

***Гурав. Уг маргаанд холбогдуулан Татварын ерөнхий газраас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбарт:***

“1.Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн талаар,

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн “хуулиар ногдуулсан албан татвар төлөх;” үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ гэж иргэний үндсэн үүргийг, Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.20 дахь заалтад “татвар төлөгч” гэж татварын хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүрэг бүхий этгээд, эсхүл суутган төлөгчийг;” ойлгоно гэж тодорхойлсноор Үндсэн хуулиар хүлээлгэсэн үүргийн хэрэгжилтийг татварын хууль тогтоомжоор зохицуулсан.

Татварын алба нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд татварын алба болон татвар төлөгчийн эрх, үүргийн тэнцвэрийг хангах үүднээс хууль тогтоомжид туссан зарим зохицуулалтыг илүү боловсронгуй болгон хуульд тусгах шаардлагатай болсон. Татварын тэгш, шударга зарчмыг бэхжүүлэх, татвар хураах үйл ажиллагааг сайжруулах, шинэ түвшинд гаргаж гүйцэтгэлийн эрх мэдлийг өөрчлөх, татвар төлөхөөс зайлсхийх явдлыг таслан зогсоох, татварын өр төлбөрийг барагдуулах ажиллагааг үр дүнтэй хийх шаардлагын улмаас эрсдэлтэй



буюу татвар төлөхөөс зугтдаг, татварын өр төлөхөөс зайлсхийдэг татвар төлөгчийн тодорхой мэдээллийг татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлэх хууль эрх зүйн зохицуулалт юм. Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэгт зааснаар татварын алба нь татвар төлөгчийн мэдээллийн нууцлалыг задруулахгүй байх үүрэгтэй бөгөөд зөвхөн татварын хууль тогтоомж зөрчсөн асуудлаар шалгах эрх бүхий татварын улсын байцаагч, хэрэг бүртгэгч, мөрдөгч, прокурор, шүүгчид тухайн шалгаж буй асуудлаар татварын албаны даргын шийдвэрээр танилцуулахаас бусад тохиолдолд татвар төлөгчийн мэдээллийг бусдад өгөх, задруулахыг хориглосон зохицуулалтыг хуульд тусгасан.

Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар татварын алба татварын төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно.” гэсэн зохицуулалт нь тухайн татвар төлөгчийн зөвхөн татварын хууль тогтоомжоор хүлээсэн үүрэгтэй холбоотой буюу хуульд заасан “тодорхой” нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийтэд мэдээлэхээр заасан юм. Түүнчлэн Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Татвар төлөгч зөвшөөрсөн, эсхүл хууль болон сонгон шалгаруулалтын шаардлагаар олон нийтэд мэдээлэх татвар төлөгчийн нэр, дугаар, төлсөн татварын мэдээлэл, статистикийн зорилгоор татварын албанд нэгтгэсэн нэгдсэн тайлан, мэдээ энэ хуулийн 13.1-д хамаарахгүй.” гэж хуульчилснаар татвар төлөгчийн хувийн болон захидал харилцааны нууцад халдах нөхцөл байдал үүсэхгүй, татвар төлөгчийн зөвхөн улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татварын хэмжээ, тайлант оны татварын өр зэрэгтэй холбоотой мэдээлэл юм. Татварын албаны зүгээс татварын хууль тогтоомж даган мөрдөлт өндөр, төлсөн татварын тоо хэмжээгээр тэргүүлж татварын хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэг татвар төлөгчийн мэдээллийг жил бүр нийтэд ил болгон мэдээлэх үүргийг тэнцвэртэй хэрэгжүүлж байгаа болно.

Татварын хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, татвар төлөгчийг эрсдэлээс хамгаалах зорилгоор татвар төлөгчийн эрсдэлийг тооцох явцад бараа, ажил, үйлчилгээ борлуулаагүй атлаа борлуулалт хийсэн мэтээр нэмэгдсэн өртгийн албан татварын баримт үйлдэж татвараас зайлсхийсэн, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн байж болзошгүй этгээдийн үйлдлийг шалгуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлж, нэрсийг Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт заасны дагуу Цахим татварын систем (etax.mta.mn)-ийн “Эрсдэл” цэсэд байршуулж байна.

Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт заасан татвар төлөгчийг хэрхэн нийтэд мэдээлэх талаар тусгайлан

журамлаагүй хэдий ч татварын албанаас гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийсэн татвар төлөгчийг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлж, зөвхөн тэдгээрийн нэрсийг ил тод байршуулж байна. Өнөөдрийн байдлаар хуульд заасан татварын өр төлөхөөс зайлсхийдэг, эрэн сурвалжлагдаж байгаа болон нэг зөрчлийг удаа дараа давтдаг этгээдийг нийтэд ил тод зарлаагүй. Одоогийн байдлаар татварын хууль тогтоомж зөрчсөн татвар төлөгчдийн мэдээллийг нийтэд ил тод цахим татварын системд байршуулснаар бусад татвар төлөгчдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой бөгөөд түүний үр дүнгүүдээс нэмэгдсэн өртгийн албан татварын хий бичилт хийсэн аж ахуйн нэгжүүдээс худалдан авалтын хий бичилттэй баримт авч, төсөвт төлөх албан татварын дүнгээ бууруулсан 6717 татвар төлөгч 2016-2023 онд 2.6 их наяд төгрөгийн худалдан авалтын дүнг тайланд залруулж, 262.3 тэрбум төгрөгийн татварын ногдол нэмэгдүүлэн тайлагнасан. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад заасныг хэрэгжүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг болон 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт тусгасан “хууль тогтоомж” гэсэн нэр томъёоны хүрээ, хязгаар буюу татварын хууль тогтоомжийн хамрах хүрээ нь Татварын ерөнхий хуулийн зорилтод заасан татварын харилцаатай холбоотой хууль түүнчлэн түүнийг дагаж биелүүлэхтэй холбоотой захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинж бүхий захиргааны хэм хэмжээний актыг хамарна. Татварын ерөнхий хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах, хөнгөлөх, чөлөөлөх, суутган тооцох, буцаан олгох эрх зүйн үндсийг тогтоож, Монголын Татварын алба /цаашид “Татварын алба” гэх/, татвар төлөгч болон энэ хуулийн дагуу татварын албаны өмнө үүрэг хүлээсэн бусад этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан.

2.Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1 болон 34.4.3 дахь заалтын талаар,

Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1 дэх заалтад татвар төлөгчийн дансны мэдээлэл болон уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээллийг татварын албаны шаардсанаар тухай бүр, 34.4.3 дахь заалтад татвар төлөгчийн дансны гүйлгээний мэдээллийг татварын албанаас албан бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн татварын албанд хүргүүлнэ гэж тус тус заасан байна. Энэ зүйл заалтыг шинэчлэн баталж Татварын ерөнхий хуульд оруулах болсон үндэслэл нь Европын холбооноос Монгол Улсыг “Татварын зорилгоор хамтран ажилладаггүй



улсын саарал жагсаалт”-д 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдөр оруулсан. Учир нь татварын албанд арилжааны банкны мэдээлэл хаалттай, Глобал форумд элсэж ороогүй, конвенцод нэгдэн орох амлалт өгөөгүй шалтгаанаар саарал жагсаалтад багтсан тул Монгол Улс нь 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Глобал форумд элсэж, арилжааны банкны мэдээллийг зөвхөн татварын зорилгоор ашиглаж, харилцан солилцох хуулийн өөрчлөлт хийж, конвенцод нэгдэн орох амлалт өгч тус жагсаалтаас гарсан. Дээрх амлалтыг биелүүлэх ажлын хүрээнд Татварын ерөнхий хуульд өөрчлөлт орсон.

Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасны дагуу татвар төлөгчийн талаар хөндлөнгийн мэдээлэл цуглуулж, мэдээллийг татварын зорилгоор ашиглаж байна. Монгол Улс Татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай конвенцод нэгдэн орох гарын үсгийг 2019 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Бүгд Найрамдах Франц Улсын Парис хотноо зурсны дагуу Татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр баталж, тус конвенц 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байна. Конвенцын хүрээнд банкны мэдээллийг зөвхөн татварын зорилгоор гадаад улстай харилцан солилцож байгаа бөгөөд 2026 оны 9 дүгээр сараас санхүүгийн дансны мэдээллийг гадаад улстай автоматаар харилцан солилцох ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг амлалтыг хүлээсэн. Олон улсын нэгдэн орсон конвенцоор хүлээсэн үүргийг биелүүлэх, татварын зорилгоор бусад улсуудтай мэдээлэл харилцан солилцох олон улсын стандартыг дагаж мөрдөх зорилгоор мэдээлэл солилцоо, ил тод байдал, мэдээллийн нууцлалтай холбоотой шаардлагыг хуульд тусгасан.

Татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай конвенц (цаашид Конвенц гэх)-ын дагуу Монгол Улс татварын зорилгоор конвенцын гишүүн орнуудтай гурван төрлөөр (үүнд: хүсэлтээр, сайн дураар, автоматаар) харилцан мэдээлэл солилцох үүрэг хүлээсний дагуу Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтад заасан мэдээллийг Гадаад улсын эрх бүхий байгууллагатай харилцан мэдээлэл солилцох журмын дагуу солилцдог. Гадаад улсын эрх бүхий этгээдээс мэдээлэл авах хүсэлт ирүүлсэн тохиолдолд Сангийн сайдын 2020 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 175 дугаар тушаалаар батлагдсан Гадаад улсын эрх бүхий этгээдтэй татварын зорилгоор хүсэлтээр болон сайн дураар мэдээлэл харилцан солилцох журмыг баримтлан мэдээллийг цуглуулж, хүргүүлэх ажиллагааг хэрэгжүүлдэг. Татварын зорилгоор ил тод байдал, мэдээлэл солилцооны Глобал форумын гишүүн орон нь хүсэлтээр харилцан мэдээлэл солилцох олон улсын стандартыг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд хэрэгжилтийн байдалд нь “Глобал форум” хяналт тавьж ажилладаг. Глобал форумгаас 2016 онд гаргасан гарын авлагын

А.3 дугаар элементийн А.3.1-д “Банкны мэдээлэлд данстай холбоотой бүртгэл, холбогдох санхүүгийн болон гүйлгээний мэдээлэл, түүний дотор дансны хууль ёсны болон ашиг хүртэгч эзэмшигчийн талаарх мэдээллийг агуулсан байх ёстой” гэж заасан мэдээллийг солилцож ажиллаж байна.

Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлээр татварын алба татвар төлөгчийн талаар мэдээлэл цуглуулж, хөндлөнгийн мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээллийг татварын хяналт шалгалт, татвар ногдуулалт, хураалт болон татвар төлөгчийн эрсдэлийн бүртгэлийн үйл ажиллагаанд зөвхөн татварын зорилгоор ашиглах, бусад байгууллага хуульд заасан мэдээллийг гаргаж өгөх, хамтран ажиллах үүргийг хуульчилсан. Дээрх зохицуулалтын дагуу арилжааны банкуудтай “Мэдээлэл харилцан солилцох, хамтран ажиллах гэрээ” байгуулан Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг болон мөн зүйлийн 34.4.2 дахь заалтад заасан мэдээллийг цахим хэлбэрээр татварын албаны хөндлөнгийн мэдээллийн санд хүлээн авч байна. Татварын албаны бүртгэл мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээллийг албаны нууцад хамааруулдаг бөгөөд төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, “Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, сангийн мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглалтад хяналт тавих журам”, “Хэрэглэгчийн эрхийн тохиргооны журам”-ын дагуу харах, ашиглах эрхийг албан хаагчдад тодорхой хязгаартайгаар олгодог.

Татварын ерөнхий газар нь банкны мэдээллийг авч татварын албаны хөндлөнгийн мэдээллийн санд бүртгэснээр зөвхөн татварын албаны даргын эрх олгосноор танилцах эрх бүхий албан тушаалтан уг мэдээлэлтэй зохих журмын дагуу танилцаж, хадгалалт, хамгаалалтыг хариуцах үүрэгтэй. Харин татварын албаны хэмжээнд бүх албан хаагч мэдээллийг ашиглах болон харах эрхгүй байдаг. Татварын албаны ажилтан, албан тушаалтан нь төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг үүргийн дагуу төрийн болон албаны нууцын хууль тогтоомжтой танилцаж, албаны нууцад хамаарах цахим мэдээлэл алдагдах, үрэгдэх эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилладаг.

Татварын алба нь Татварын ерөнхий хуулийн зохицуулалтын хэрэгжилтэд хяналт тавих, хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдахаас сэргийлэх хүрээнд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Олон улсын 130 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, 130/1ЕС 27001:2013 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартыг хэрэгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын үүднээс эрхийн тохиргоо, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн журмыг баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.



Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар татварын хяналт шалгалтыг татварын алба эрсдэлд, эсхүл татвар төлөгчийн хүсэлтэд үндэслэн хийж гүйцэтгэх зохицуулалтын дагуу эрсдэлд суурилсан татварын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд арилжааны банканд тухайн татвар төлөгчийн “дансны гүйлгээний мэдээлэл”-ийг албан хүсэлтээр гаргуулан авдаг бөгөөд тодорхой давтамжтай авдаггүй.

Татварын алба арилжааны банкттай Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 34.4 дэх хэсгийг үндэслэн мэдээлэл харилцан солилцох, хамтран ажиллах гэрээг байгуулсан ба хуулийн 34.4.3 дахь заалтад заасан дансны гүйлгээний мэдээллийг тогтмол давтамжтай бус татвар төлөгчийн хүсэлтэд үндэслэн эрсдэл тооцох, эрсдэлд суурилсан татварын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх (хуулийн 41 дүгээр зүйл), татварын өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлэх (хуулийн 55 дугаар зүйл), татварын өрийг үл маргах журмаар гаргуулах (хуулийн 63 дугаар зүйл) зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай тухай бүр арилжааны банканд албан бичгээр хандан цахимаар гаргуулан авч байна.

Татвар төлөгчийн дансны гүйлгээний мэдээллийг гаргуулан татварын зорилгоор ашиглахдаа тухайлан дансны зарлагын мэдээллийг бус нийт гүйлгээний мэдээллийг гаргуулан татвар ногдох орлого болон татвар ногдох орлогоос хасагдах зардал, татварын ногдлыг үнэн зөв тодорхойлсон эсэхийг шалгах зорилгоор дансны орлого, зарлагын гүйлгээнээс тодруулга, тулгалт, дүн шинжилгээ хийж, татварын ногдлыг тодорхойлох үйл ажиллагаанд ашигладаг.

Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд заасан мэдээллийг татварын алба 2021-2023 онд гаргуулан авснаар гарсан өөрчлөлт, үр дагаврыг Татварын ерөнхий хууль батлагдахаас өмнөх хоёр жил (2017, 2018 он)-тэй харьцуулахад аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан ирүүлсэн, залруулсан татвар төлөгчийн тоо 24.9 хувиар, татвар төлөгчийн тайлагнасан татварын ногдол 134.9 хувиар; хувь хүний орлогын албан татварын тайлан ирүүлсэн, залруулсан татвар төлөгчийн тоо 145.9 хувиар, татвар төлөгчийн тайлагнасан татварын ногдол 344.2 хувиар тус тус нэмэгдсэн байна. Мөн Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжсэнээс хойш 4159 татвар төлөгч татан буугдах хүсэлт ирүүлсэнээс дансны мэдээлэлд үндэслэн 88.5 хувь буюу 3682 татвар төлөгчийг хяналт шалгалтад хамруулахгүйгээр татан буулгах бололцоо бүрдсэн ба 477 татвар төлөгчийг хяналт шалгалтад хамруулж, 155.4 тэрбум төгрөгийн зөрчилд 11.5 тэрбум төгрөгийн акт үйлдсэн байна.” гэжээ.

***Дөрөв. Уг маргаанд холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссоос Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбарт:***

“Арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, бусад санхүүгийн эрх бүхий байгууллагад цугларсан хүний хувийн мэдээллийг татварын албанаас гаргуулан авсан нь хүний эрхийг зөрчсөн тухай гомдлыг Комисс өнгөрсөн хугацаанд шийдвэрлээгүй байна. Харин санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч этгээд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар тогтоосон мэдээлэл хариуцагчийн үүргийг зохих ёсоор биелүүлээгүй асуудлаар 2022-2024 онд Комиссын гишүүний гурван шаардлага, нэг зөвлөмжийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлжээ.

Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт татвар төлөгч “хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй”, “нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан” зэрэг тохиолдолд татварын албаны шийдвэрээр зөрчлийг нийтэд мэдээлэх зохицуулалт нь Монгол Улсын олон улсын гэрээ (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 17 дугаар зүйл, уг заалтад холбогдох Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хорооны ерөнхий тайлбар (UN Doc: CCPR/C/GC/17), Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактаар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, гэрээний үүргээс ухрахад баримтлах Сиракузагийн зарчмуудын 10 зүйл)-ээр тогтоосон хүний эрхийн хязгаарлалт “тохирсон байх” зарчимд нийцэхгүй үр дагавар үүсгэж болно. Тодруулбал, татвар төлөх үүргээ ноцтой зөрчсөн этгээдийн нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдах замаар хуулийн хэрэгжилтийг хангах эрх зүйн зохицуулалт байж болох боловч уг заалтыг татварын зөрчлийн шинж, үнийн дүн, нийгмийн хор уршиг зэргийг харгалзан үзэхгүйгээр, бүх төрлийн татварын зөрчилд хамаарах байдлаар хуульчилсныг хэт өргөн хүрээтэй гэж үзэх үндэслэлтэй. Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн заалтын практик хэрэглээ нь уг заалт хүний эрхийн зөрчил мөн эсэхийг эцэслэн тогтооход ач холбогдолтой.

Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт заасны дагуу татварын зөрчлийг татварын албаны шийдвэрээр нийтэд мэдээлэх, ийм шийдвэрийг зөрчил гаргагч этгээдэд урьдчилан мэдэгдэх, шийдвэрийн эсрэг баримт, үндэслэл, гомдол гаргах зохицуулалт байхгүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14 дүгээр зүйлд баталгаажуулсан хэргээ шударгаар шүүлгэх эрхэд нийцэхгүй байж болно. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14 дүгээр зүйл, уг заалтад холбогдох Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хорооны ерөнхий тайлбар (UN Doc: CCPR/C/32)-ын дагуу хэргээ шударгаар шүүлгэх эрхэд хамаарах хэм хэмжээ шүүх болон маргаан таслах эрх бүхий байгууллагуудад хамааралтай.



Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3 дахь заалтын дагуу татварын албанаас гаргуулж авах хүний хувийн мэдээллийг хэт өргөн хүрээтэй хуульчилсан байж болзошгүй байна. Татварын алба хүний хувийн мэдээллийг зөвхөн хууль ёсны зорилгыг хангах хэмжээнд гаргуулж авах эрх зүйн хамгаалалт бий болгоогүй нь татварын алба хүний хувийн мэдээллийг их хэмжээгээр гаргуулж авах, халдашгүй чөлөөтэй байх эрхэд дур зоргоор халдах нөхцөлийг бодит байдалд үүсгэх боломжтой.” гэсэн байна.

***Тав. Уг маргаанд холбогдуулан зарим арилжааны банкнаас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн албан бичигт:***

“1.ХААН банкнаас: Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3 дахь заалтад заасан мэдээллийг татварын албанаас шаардсан тухай бүр гарган хүргүүлдэг бөгөөд 2024.01.01-2024.03.31-ний өдрийг дуусталх хугацаанд нийт 16 албан бичгийг хүлээн авч 18,506 харилцагчийн 22,518 дансны хуулгыг Татварын ерөнхий газрын цахим хаягт хүргүүлсэн байна.

Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсэгт “Арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон бусад санхүүгийн эрх бүхий байгууллага дараах мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ.” гээд 34.4.1-т “татвар төлөгчийн дансны мэдээлэл болон уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээллийг татварын албаны шаардсанаар тухай бүр;”, 34.4.2-т “татвар төлөгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон бусад санхүүгийн эрх бүхий байгууллагад шинээр төлбөр тооцоо, хадгаламжийн болон бусад төрлийн данс нээсэн, эсхүл өмнө нээсэн дансанд өөрчлөлт, хөдөлгөөн хийлгэсэн бол энэ тухай мэдээллийг тухай бүр;”, 34.4.3-т “татвар төлөгчийн дансны гүйлгээний мэдээллийг татварын албанаас бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг үндэслэн.” гэж, Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг дор дурдсанаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөх, задруулах, ашиглахыг банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, хянан шалгах зөвлөл, ажилтанд хориглоно.” гэж заасан бөгөөд 7.2.8 дахь заалтад “Гааль, татварын алба тодорхой харилцагчийн гааль, татварын өр төлбөрийг төлүүлэхээр болон татварын хяналт шалгалт хийхээр хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан.” тохиолдолд харилцагчийн дансны мэдээллийг гаргаж татварын албанд хүргүүлдэг. Банк хуульд заасан дээрх үүргээ биелүүлээгүй, зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 7.3 дахь хэсэгт “татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй;” гэх үндэслэлээр 4 сая төгрөгөөр торгуулах эрсдэлтэй байдаг.

ХААН банк ХК нь иргэн, хуулийн этгээдтэй байгуулах харилцах дансны гэрээнд хуульд заасан эрх бүхий байгууллага /шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, татвар, нийгмийн даатгал зэрэг/-ын мэдэгдэл, шаардлагаар харилцагчийн данс, түүнтэй холбоотой бусад мэдээллийг гаргаж өгөх, данснаас суутгал хийх, түүнчлэн хуулиар хүлээсэн үүргийн дагуу харилцагчийн данс, түүнтэй холбоотой бусад мэдээллийг эрх бүхий байгууллагад тогтсон хугацаанд мэдээлэх, эдгээр үйлдлийг хийсэн тохиолдолд энэ талаар харилцагчид мэдэгдэл хүргүүлэхгүй байхаар гэрээгээр харилцан тохиролцсон. Өөрөөр хэлбэл энэ тохиолдолд харилцагчид мэдэгдэл ирүүлэхгүй байж болохыг хүлээн зөвшөөрч гэрээгээр баталгаажуулсан. Мөн иргэн, хуулийн этгээдийг харилцагчаар бүртгэх, мэдээллийг шинэчлэхдээ хувийн мэдээллийг ашиглах, гуравдагч этгээдэд дамжуулах талаар харилцагчид урьдчилан мэдэгдэж, мэдээллийн зэний зөвшөөрлийг авч байна.

2.Худалдаа, хөгжлийн банк: Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсэгт “Арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон бусад санхүүгийн эрх бүхий байгууллага дараах мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:” гээд, 34.4.1 дэх заалтад “татвар төлөгчийн дансны мэдээлэл болон уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээллийг татварын албаны шаардсанаар тухай бүр;”, 34.4.3 дахь заалтад “татвар төлөгчийн дансны гүйлгээний мэдээллийг татварын албанаас бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг үндэслэн.” гэж тус тус заасан болон Татварын ерөнхий газартай 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр байгуулсан ТEG01/01, TDBM/17/2021 тоот Хамтран ажиллах гэрээний 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн татварын албанаас тухай бүр албан бичгээр болон цахимаар ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Татварын ерөнхий газарт холбогдох мэдээллийг гарган өгч байна. Татварын ерөнхий хуулийн дээрх зохицуулалтын хүрээнд дээр дурдсан Хамтран ажиллах гэрээний дагуу Худалдаа, хөгжлийн банк нь 2024 оны эхний улиралд Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1 дэх заалтад заасны дагуу давхардсан тоогоор нийт 120,676 (нэг зуун хорин мянга зургаан зуун далан зургаа) татвар төлөгчийн дансны мэдээлэл болон уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээлэл, 34.4.3 дахь заалтад заасны дагуу давхардсан тоогоор нийт 99,011 (ерэн есөн мянга арван нэг) татвар төлөгчийн дансны гүйлгээний мэдээллийг тус тус Татварын ерөнхий газар болон харьяа татварын албанд гаргаж өгсөн байна.

Дээрх мэдээллийг Худалдаа, хөгжлийн банк нь Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг дор дурдсанаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөх, задруулах, ашиглахыг банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх



удирдлага, хянан шалгах зөвлөл, ажилтанд хориглоно.” гээд 7.2.8 дахь заалтад “Гааль, татварын алба тодорхой харилцагчийн гааль, татварын өр төлбөрийг төлүүлэхээр болон татварын хяналт шалгалт хийхээр хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан.” гэж заасанд нийцэж байгаа гэж үзэн Татварын ерөнхий газарт гарган өгч байгаа билээ.

Татварын ерөнхий газар нь Банкны тухай хууль, Татварын ерөнхий хуульд заасны дагуу мэдээллийг банкнаас шаардаж байгаа бөгөөд энэ тохиолдолд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Мэдээлэл хариуцагч хуульд зааснаас бусад тохиолдолд мэдээллийг боловсруулах, цуглуулах, ашиглахдаа мэдээллийн эзнээс зөвшөөрөл авна.” гэж зааснаар мэдээлэл хариуцагч нь мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах шаардлагагүй юм. Тодруулбал, мэдээлэл хариуцагч болох Худалдаа, хөгжлийн банк нь татварын алба руу илгээж буй мэдээллийг Банкны тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу илгээж байх тул мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах шаардлагагүй байна. Мөн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Дараах тохиолдолд мэдээлэл хариуцагч мэдээллийн эзэнд мэдэгдэл даруй өгнө.” гээд 21.1.2 дахь заалтад “мэдээллийн эзний зөвшөөрлөөр мэдээлэл боловсруулахаас бусад үндэслэл, зорилгоор мэдээлэл боловсруулсан, боловсруулсан мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулсан;” гэж заасан ба энэхүү заалт нь мэдээллийн эзний зөвшөөрөл авсан мэдээлэлтэй холбогдохоор байна. Өөрөөр хэлбэл, татвар төлөгчийн дансны мэдээлэл болон түүнтэй холбогдох мэдээллүүд нь мэдээллийн эзний зөвшөөрөлтэйгөөр мэдээлэл хариуцагчид боловсруулахаар өгсөн мэдээлэл биш байх тул бусад этгээдэд дамжуулахад мэдээллийн эзэнд мэдэгдэх шаардлагагүй юм.” гэсэн байна.

***Зургаа. Уг маргааныг Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэх ажиллагааны явцад Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Н.Лхамцэрэнг шинжээчээр томилж, дүгнэлт гаргуулсан. Уг дүгнэлтэд:***

*1.Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн заалт Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч буюу энэ тохиолдолд татварын алба хуульд заасан чиг үүрэг, бүрэн эрхээ хэрэгжүүлж олж авсан мэдээллийг хадгалах, хамгаалах үүрэг, мэдээллийн эзний холбогдох эрхийг хөндөх эсэх:*

... Европын холбоо, Их Британи, АНУ, Солонгос болон Латин Америкийн орнуудад өртэй татвар төлөгчийн хувийн мэдээллийг түүний зөвшөөрөлгүйгээр дэлгэх нь тийм ч содон зүйл биш. Учир нь өртэй татвар төлөгчдийн хувийн мэдээллийг агуулсан нэг төрлийн хар жагсаалтыг

нийтэд ил болгосноор татварын өр барагдуулалтыг нэмэгдүүлэх, татварын сахилга батыг чангаруулах улмаар татварын тайлагнал мэдүүлгийг нэмэгдүүлэх зэрэг нөлөөлөлтэй учраас том зургаар нь харвал улсын төсөвт төвлөрөх татварын орлогыг өсгөнө гэх хүлээлттэйгээр ашиглаж, хүлээн зөвшөөрдөг. Түүнчлэн өртэй татвар төлөгчийн нэрсийн жагсаалтыг дэлгэх нь хамгийн бага зардлаар татварын тайлагнал, төлөлтийг нэмэгдүүлэх арга гэж үздэг. Улс бүрд ямар тохиолдолд буюу хэдий хэмжээний татварын өрийг хэр хугацаанд төлөөгүй болох, цаашлаад татвар төлөгчийн аль хувийн мэдээллийг, ямар арга хэлбэрээр олон нийтэд дэлгэх, хэрвээ олон нийтэд хувийн мэдээллийг дэлгэхээр бол татвар төлөгчид мэдэгдэх эсэх зэргийг олон янз байдлаар тусгажээ. Аль ч улсад өртэй татвар төлөгчдийн жагсаалтыг дэлгэхийг бүрэн эсэргүүцээгүй буюу гагцхүү хувийн мэдээллийг дэлгэхдээ хувь хүний нууцыг хамгаалах, хувийн амьдралын халдашгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг аль болох бага байлгахад анхаарах зэрэг олон хүчин зүйлсийг харгалзахыг шаардаж байна.

Маргаан бүхий зохицуулалтын агуулгыг бичвэр талаас нь нарийвчлан авч үзвэл, “хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан” гэх хэсэг нь нийлмэл диспозици буюу энэ бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан татвар төлөгчийн мэдээллийг нийтэд мэдээлнэ. Үүнд ямар төрлийн татварын зөрчил гэдгийг тодорхойлоогүй, зөвхөн нэг татварын зөрчлийг гурав ба түүнээс дээш удаа гаргасан байхыг заажээ. Татварын зөрчил нь дотроо хүнд, хөнгөн олон төрөл бий. Тухайлбал, татварын тайлангаа хайхрамжгүй байдлын улмаас цөөхөн хоног хэтрүүлэх, санаатайгаар татварын тайлан дээрх орлогоо нуун дарагдуулах, эсхүл татварын хяналт шалгалтын үеэр шаардсан баримт бичгийг үрэгдүүлэх зэргээр олныг дурдаж болно.

Үүнээс гадна “нийтэд мэдээлж болно” гэсэн нь тухайн татварын албанд заавал мэдээлэх үүрэг хүлээлгээгүй харин ч мэдээлэх эрх олгохоор заажээ. Энэ нь татвар төлөгчийн мэдээллийг нийтэд мэдээлэх эсэхийг шийдвэрлэх тодорхой шалгуур байхгүй бөгөөд татварын алба бүр тус зохицуулалтыг өөрсдийн үзэмжээр хэрэглэх боломжтойг илтгэж байна. ... Хийсвэр жишээ авахад хөнгөн зөрчил олон удаа гаргасан 8 сая төгрөгийн татварын өртэй этгээд болон хүнд зөрчил олон удаа гаргасан 80 сая төгрөгийн татварын өртэй этгээдийг ямар татварын байцаагч хариуцан авснаас хамаарч харилцан адилгүй үр дүнд хүрч болохоор байна. Учир нь манай одоогийн зохицуулалтын хүрээнд, татварын зөрчил үйлдсэн тооны тухайд “гурав ба түүнээс дээш удаа нэг зөрчлөө давтан үйлдсэн байх” гэх нэг нөхцөлийг тодорхойлж өгсөн. Үүнээс бусдаар ямар зөрчил байх, татварын өрийн хэмжээ, татварын өр эцэслэн тогтоосноос хойших хэдий хугацааны дараа мэдээллийг дэлгэх, хэрвээ татвар төлөгчдийн мэдээллийг олон нийтэд дэлгэхээр бол ямар хэлбэрээр хүргэх буюу

цахим хуудаст байршуулах, хэвлэлийн бага хурал зарлах, өдөр тутмын сонин сэтгүүлд нийтлэх эсэх, татвар төлөгчийн аль мэдээллийг нийтэд дэлгэх (гэрийн хаяг, овог нэр, татвар төлөгчийн дугаар, өрийн хэмжээ, едийг хүртэл төлсөн татвар өрийн хэмжээ зэргээс алийг багтаах), тухайн нийтэд дэлгэсэн мэдээлэл нь хэзээ алга болох эсэх, нийтэд дэлгэхээс өмнө татвар төлөгчөөс холбогдох мэдээлэл нь үнэн зөв эсэхийг тодруулах эсэх (эс бөгөөс худал мэдээлэл нийтэд түгээсний улмаас татвар төлөгчийн нэр хүнд сэвтэх, санхүүгийн хохирол хүлээж ч болзошгүй) зэрэг олон хүчин зүйлсийг хуульчлаагүй орхигдуулсан.

Эдгээрээс хамгийн ноцтой нь өртэй татвар төлөгчийн мэдээллийг дэлгэх эсэх эцсийн шийдвэрийг тухайн татварын албаны дарга, эсхүл хариуцсан татварын улсын байцаагч, эсхүл улсын ахлах байцаагч гээд чухам хэн гаргах нь мөн тодорхойгүй байна. ... Эсрэгээрээ татвар төлөгчийн мэдээллийг хэрхэн, яаж, хэзээ нийтэд мэдээлэхээ тогтоож чадахгүйн улмаас маргаан бүхий зохицуулалтыг хэрэгжүүлэхээс зайлсхийж, ажлаас хойш суух татварын албанд бүртгэлтэй татвар төлөгчдийн хувьд татвараа төлөхгүй бол нэрс нь олон нийтэд ил болох талаар бодох ч шаардлага байхгүй, үүнийг мэдэх ч үгүй байх болов уу. Иймэрхүү эрсдэлийн улмаас хувийн мэдээллийг нийтэд дэлгэснээр хүрэхийг зорьж буй үр дүндээ ойртох ч үгүй, харин ч хүний эрхийн зөрчил гаргах хуулийн цоорхой байж болох юм.

*2.Дээр дурдсан хуулийн заалтад татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болохоор заасан нь иргэнд хууль зүйн хариуцлага хүлээлгэж буй эсэх, мөн уг зохицуулалтын эрх зүйн онолын үзэл баримтлал, үндэслэл, түүнийг бусад улс хууль тогтоомждоо хэрхэн тусгасан байдаг хандлага, үндэслэлийн судалгаа:*

Дэлхий даяар татварын албаны зүгээс гурван өөр хүрээний татвар төлөгчдийн хувийн мэдээллийг нийтэд дэлгэдэг ажээ. Нэгдүгээрт, Австрали, Дэнмарк, Франц, Финланд, Норвеги, Филиппин, Швед зэрэг орнууд татвар төлөгчдийн татварын тайланг бүхэлд нь дэлгэдэг; хоёрдугаарт Канад, АНУ, Их Британи, Португал, Энэтхэг, Грек, Чех зэрэг орнуудад тодорхой зорилтот мэдээлэл буюу өртэй татвар төлөгчид болон татварын эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдийн мэдээллийг дэлгэдэг; гуравдугаарт, Япон, БНСУ, Пакистан зэрэг орнуудад сайн татвар төлөгчдийн мэдээллийг тус тус дэлгэдэг. Татварын мэдээллийг олон нийтэд дэлгэх нь татварын бодлогын хэлэлцүүлгийг хөнгөвчлөх, татвар төлөлтийг нэмэгдүүлэх, ялангуяа хүчин чадал багатай татварын албанд бага зардлаар татварын тайлагналыг нэмэгдүүлэхэд туслах, татварын албыг хариуцлагажуулах, санхүүгийн зах зээлийн үйл ажиллагааг сайжруулах, улс бүрээр үнэ шилжилтийн тайлан боловсруулалтыг хялбарчлах зэрэг ач холбогдолтой. Нөгөөтээгүүр, хувийн мэдээллийг олон нийтэд дэлгэснээр хувийн орон зай болон хувийн

нууцад халдах, улмаар татвар төлөгч нарыг олон нийтийн зүгээс үзүүлэх дарамт, айлган сүрдүүлэлтэд өртөж болзошгүй нөхцөл байдалд оруулах, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг багасгах, татварын тайлагналыг бууруулах зэрэг сөрөг нөлөөлөлтэй байж болохыг дурджээ. Түүнчлэн, аливаа улс ямарваа татвар төлөгчдийн мэдээллийг нийтэд дэлгэхээ тухайн татварын төлөгчдөөс орж ирэх төсвийн орлого, татвар төлөгчдийн мэдээллийг нээлттэй байлгахад зарцуулах зардал, түүнчлэн уг мэдээлэлд багтсан хувь хүн, байгууллагын нууцыг хамгаалахад анхаарах ёстой.

Европын холбооны гишүүн орнуудын дунд явуулсан судалгаанаас үзвэл, хэлэлцэн тохирогч улсын 21 нь төрийн эрх баригчид хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүй татвар төлөгчдийн хувийн мэдээллийг тодорхой нөхцөлд олон нийтэд ил болгож болох ба зарим тохиолдолд заавал ил болгох ёстой. Үүний зэрэгцээ, нийтлэх мэдээллийн цар хүрээ, нийтлэх урьдчилсан нөхцөл, түүний дотор төлөгчдөөгүй татварын өрийн хэмжээ, татварын өр төлөөгүй хугацаа зэргийг үндэсний хууль тогтоомжоор янз бүрээр тогтоосон. Ихэнх улсууд татвар төлөгчийн мэдээлэлд хязгаарлалтгүй хандах боломжийг олгодог. Цаашилбал судалгаанд хамрагдсан хэлэлцэн тохирогч улсуудаас зөвхөн найм нь татвар төлөгчдийн гэрийн хаягийг дэлгэдэг бол хоёр улс нь тэдний оршин суугаа хотын захиргааг нийтэд дэлгэдэг. Тухайлбал, Ирландад өртэй татвар төлөгчийн овог нэр, гэрийн хаяг, тухайн этгээдийн татварын хууль тогтоомжийн эсрэг үйлдэл, эс үйлдэхүйд ногдуулсан торгууль, бусад шийтгэл, ажил мэргэжил, торгуулийн хэмжээ, оногдуулсан ял, хэд дэх удаагаа шийтгүүлсэн болох, нэмэлт мэдээллийг багтаасан хүснэгт бүхий жагсаалтыг улирал тутам шинэчлэн Ирландын гааль, татварын газрын цахим хуудас дээр байршуулна.

Португал Улсын Татварын ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 5 ба 6-д заасны дагуу, хуульд заасан хугацааны дотор сайн дураараа татвараа төлөөгүй, татварын барьцаа гаргаж өгөөгүй, татвараас чөлөөлөх хүсэлт гаргаагүй өртэй татвар төлөгчийн жагсаалтыг хувь хүн ба аж ахуйн нэгж хэмээн ангилан, өрийн хэмжээгээр нь тус тусдаа жагсаалт үүсгэнэ. Хувь хүний хувьд 7.500-1.000.000 евро хүртэл нийт 6 шатлалаар; аж ахуйн нэгжийн хувьд 10.000-5.000.000 дээш евро хүртэл 6 шатлалаар тус тус өртэй татвар төлөгчийн нэрсийн жагсаалтыг гаргадаг. Тус жагсаалтад татвар төлөгчийн бүртгэлийн дугаар болон нэрийг нь жагсаасан байна. Энэхүү жагсаалтын зорилго нь олон нийтэд ил тод байх бөгөөд энэхүү жагсаалтад татвар төлөгчийн нэрийг оруулахаас өмнө мэдээллийг үнэн зөв эсэхийг баталгаажуулах үүднээс татвар төлөгчтэй урьдчилан сонсох ажиллагааг явуулан, татварын өрийн гэрчилгээ үйлддэг.

Унгар Улсын өртэй татвар төлөгчийн нэрсийн жагсаалт нь Европын хүний эрхийн тухайн конвенцын 8 дугаар зүйл буюу хувийн



болон гэр бүлийн амьдрал, гэр орон, захидал харилцааны халдашгүй байдлыг хүндэтгэх талаарх зохицуулалтыг зөрчсөн эсэх үндсэн эрхийн маргааныг Европын хүний эрхийн шүүх 2023 оны 3 дугаар сарын 09-ний өдөр эцэслэн шийдвэрлэж үндсэн эрхийн зөрчлийг Унгар Улс гаргасан гэж үзсэн. Маргааны гол агуулга нь Унгарын нэгэн жижиг бизнес эрхлэгч татварын өрөө төлөөгүйн улмаас харьяа хотын татварын албаны өртэй татвар төлөгчдийн нэрсийн жагсаалтаар түүний овог нэр, гэрийн хаяг, аж ахуйн нэгж бол нэр, татварын өрийн хэмжээ зэрэг мэдээллийг нийтэд дэлгэсэн. Гомдол гаргагч бизнес эрхлэгчийн зүгээс Унгар Улсын Засгийн газар нь өртэй татвар төлөгчийн нэрсийн жагсаалтыг нийтэд түгээх нь татвар төлөгчдийн татварын тайлагналыг сайжруулах, татвар төлөлтийг нэмэгдүүлж буй эсэхийг огт нягталдаггүй, харин ч жагсаалтын улмаас татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгж нь нэр хүндээ алдах, олон нийтийн зэмлэл хүртдэг хэмээн маргасан. Европын хүний эрхийн шүүхээс дараах гурван зүйлийг харгалзан дүгнэлт хийсэн. Нэгдүгээрт, хуульд үндэслэсэн байх буюу 2003 оны Унгарын захиргааны актын 55 дугаар зүйлийн 55.5-д заасны дагуу өртэй татвар төлөгчдийн мэдээллийг дэлгэж буй тул эрх зүйн үндэслэл нь асуудалгүй юм. Хоёрдугаарт, хууль ёсны зорилгыг биелүүлэх үүднээс хүний эрхэнд халдсан байх явдал болно. Энэ тохиолдолд хоёр гол зорилгыг хэрэгжүүлэхийн тулд өртэй татвар төлөгчдийн мэдээллийг нийтэд дэлгэж байгаа. Эхнийх нь улс орны эдийн засгийн сайн сайхан байдлыг сайжруулах буюу татвар төлөлтийг нэмэгдүүлж, татварын сахилга батыг сайжруулснаар улсын төсөвт төвлөрөх татварын орлого нэмэгдэх боломжтой, удаах нь бизнес эрхлэгч нарт хандан ил тод, найдвартай бизнесийн хамтрагчийг санал болгох замаар бусдын эрх болон эрх чөлөөг хангахыг зорьсон учраас хууль ёсны зорилго байж чадна. Гуравдугаарт, ардчилсан улсад энэ арга хэмжээ нь зайлшгүй эсэх буюу энэ шалгуур нь өргөн хүрээнд улс орныхоо эдийн засгийн сайн сайхан байдлыг хангах, нийт бизнес эрхлэгч нарт найдвартай, сайн хамтрагчийг санал болгох зорилгыг хэрэгжүүлэхийн тулд зайлшгүй өртэй татвар төлөгчдийн гэрийн хаягийн мэдээллийг интернэтээр, бүх нийтэд хаанаас ч нээлттэйгээр байршуулах шаардлага байсан эсэхийг бүрэн тодруулах тухай асуудал юм.

Дээрх гурван зүйлээс хамгийн эргэлзээтэй, авч үзэх ёстой нь “ардчилсан улсад энэ арга хэмжээ зайлшгүй байх ёстой эсэх”, өөрөөр хэлбэл өрсөлдөж буй нийтийн болон хувийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх үүднээс хүлээн зөвшөөрөх хязгаарын дотор үйл ажиллагаа явуулсан эсэхийг доорх шалгуураар тусгайлан авч үзье.

Хүлээн зөвшөөрөх хязгаарын үйл ажиллагаа ба хамрах хүрээ:

1/Ерөнхий шалгуур: Тухайн арга хэмжээ нь хүний гол эрх, эрх чөлөөг эдлэхэд шууд нөлөөлөх эсэх; төрийн оролцооны үндсэн дээр нийтэд ил болж буй хувийн мэдээллийн онцлог шинж буюу хувь



хүний эмзэг мэдээлэл эсэх (эрүүл мэндийн байдал, шашин шүтлэгийн хандлага, бэлгийн чиг баримжаа зэрэг); тухайн хувийн мэдээллийг олон нийтэд дэлгэснээр үүсэх сөрөг нөлөөлөл (найдваргүй байдлын мэдрэмж, олон нийтийн доромжлол, нийгмийн амьдралаас гадуурхагдах, хувийн амьдралаа хэвийн явуулахад учирч болзошгүй саад бэрхшээл зэрэг); хувийн мэдээллийг түгээх суваг, арга хэрэгслээс хамаарч хохирлын эрсдэл (интернэтээр дамжуулан хувийн мэдээллийг түгээх нь хэвлэлээр түгээхээс илүү олон хүнд, хязгаарлалтгүйгээр хүрдэг тул хохирол ихтэй) зэрэг ерөнхий зүйлсийг бодолцох хэрэгтэй.

2/Мэдээллийн хамгаалалтын зарчмууд: Зорилгын хязгаарлалтын зарчим (Мэдээлэл хамгааллын конвенцын 5.6 дахь заалт) буюу тусгай, маш тодорхой зорилго, эсхүл эдгээрийг биелүүлэх үүднээс дагалдан гарч буй зорилгоор хувийн мэдээллийг дэлгэж болно; өгөгдлийг хамгийн бага байлгах зарчим (Мэдээлэл хамгааллын конвенцын 5.в дэх заалт) буюу хангалттай, холбогдох хязгаарлалттай мэдээллийг боловсруулах, ашиглах; өгөгдлийн үнэн зөв байдлын зарчим (Мэдээлэл хамгааллын конвенцын 5.г дэх заалт) буюу тухайн мэдээллийн эзэн нь өөрийн мэдээллийг залруулах, шинэчлэх боломжтой байх; хадгалалтын хязгаарлалтын зарчим (Мэдээлэл хамгааллын конвенцын 5.д дэх заалт) буюу зорилгыг биелүүлэхэд шаардлагатай хугацаагаар мэдээллийг хадгалах.

3/Ерөнхий арга хэмжээ ба парламентын хяналт: Европын холбооны нөхөх зарчмын дагуу гэрээлсэн орнууд конвенцод болон протокол дээр заасан эрх, эрх чөлөөг үндэсний хууль тогтоомжийн үндсэн дээр хамгаалах үүргийг хүлээдэг. Ийнхүү үндэсний хууль тогтоомжийн хүрээнд өрсөлдөж буй нийтийн болон хувийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх үүднээс ерөнхий арга хэмжээ буюу хариу арга хэмжээг тогтоохдоо сайтар нягтлах хэрэгтэй. Ерөнхий арга хэмжээ нь тухайлсан хэрэг бүр дээр үнэлгээ хийхээс илүүтэй хууль ёсны зорилгодоо хүрэхэд бодитой хувь нэмэр оруулахуйц байх ёстой ба тухайлсан нэг арга хэмжээ байх нь тодорхойгүй байдал, нэхэмжлэл, зардал болон хойшлуулах, үүгээр зогсохгүй ялгаварлан гадуурхалт, дур зоргоороо хэрэглэх эрсдэл бий болгодог. Ийм арга хэмжээний гол асуудал нь хязгаарлалт бүхий дүрэм батлах ёстой байсан уу, эсхүл уг арга хэмжээ авахгүй бол хууль ёсны зорилгодоо хүрэх боломжгүй гэдгийг төр нотолж чадах эсэх нь биш юм. Харин хууль тогтоогч ерөнхий арга хэмжээг авч, өрсөлдөж буй ашиг сонирхол хоорондын тэнцвэртэй байдлыг хангахдаа өөрт олгосон хүлээн зөвшөөрөх хязгаарын хүрээнд ажилласан уу гэдэг байгаа юм.

Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн түвшинд байгаа дотоодын эрх бүхий байгууллагууд хоорондоо өрсөлдөж буй ашиг сонирхлыг зохих ёсоор тэнцвэржүүлж, наад зах нь мөн чанарын хувьд зөвхөн (I) тухайн мэдээллийг түгээх олон нийтийн ашиг сонирхол, түүнчлэн (II) задруулсан мэдээллийн шинж чанар; (III) хувийн амьдралаа явуулахад учруулах сөрөг нөлөөлөл болон хохирлын эрсдэл; (IV) интернэтээр



мэдээлэл түгээх үеийн боломжит хүртээмж; мөн түүнчлэн (V) өгөгдөл хамгаалах үндсэн зарчмууд (зорилгын хязгаарлалт, хадгалах хязгаарлалт, өгөгдлийг багасгах, мэдээллийн үнэн зөв байдалтай холбогдох дэд зарчмууд) зэргийг зайлшгүй харгалзах шаардлагатай.

Дээрх бүх нөхцөл шалгуурыг хэргийн үйл баримттай тулган үзвэл, Унгар Улсын өртэй татвар төлөгчдийн нэрсийн жагсаалтыг нийтлэхэд татварын албаны субъектив үнэлгээ ордоггүй онцлогтой. Хуульд заасан хэмжээний өрийг зохих хугацааны турш төлөөгүй бүх иргэдийн мэдээллийг ямар нэгэн хувийн онцгой нөхцөл байдлыг харгалзахгүйгээр татварын алба нь заавал нийтэд дэлгэх ёстой. Ийнхүү хувийн байдал харгалзахгүй нийтэлж буй болоод нийтэлсэн хувийн мэдээллийн үнэн зөв байдалд асуудал байхгүй. Өртэй татвар төлөгчдийн нэрсийн жагсаалтад түүний гэрийн хаягийг тусгаж, бүх хүнд нээлттэйгээр нийтлэх явцад, улс орны эдийн засгийн сайн сайхан байдал гэх нийтийн ашиг сонирхол, нөгөө талаас хувь хүний хувийн амьдрал, орон байрны халдашгүй байдал гэх хувийн ашиг сонирхол хоёрын аль нь илүү чухал, үнэхээр нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс гагцхүү хувийн ашиг сонирхлыг хөндөх бодитой шаардлага бий эсэхийг тодруулах шаардлагатай. Европын хүний эрхийн шүүхийн зүгээс өртэй татвар төлөгчдийн мэдээллийг нийтэд ил болгох нь татварын сахилга батыг дээшлүүлэх, татварын өрийн талаар олон нийтэд ойлголт өгөх, улмаар татварын тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх гэх хууль ёсны зорилгыг хэрэгжүүлэхийг зорьсон боловч татвар төлөгчийн хувийн мэдээллийг дэлгэхдээ тодорхой хязгаар тавиагүй, интернэт ашиглан татвар төлөгчийн хувийн мэдээллийг дэлгэснээр учрах сөрөг нөлөөллийг үнэлэхгүйгээр мэдээллийг дэлгэсэн, хууль тогтоогчийн зүгээс мэдээллийг аль болох багасгах зарчим болон хувийн мэдээллийн хамгаалалтыг бодолцоогүй бөгөөд нийтийн ба хувийн ашиг сонирхлыг тэнцвэртэйгээр хангаагүй хэмээн дүгнэжээ.

Энэтхэг Улсад 2014 оноос хойш “Нэр ба Ичгүүр” гэх санаачилгыг эхлүүлж, Засгийн газрын цахим хуудас болон сонин дээр өртэй татвар төлөгчдийн нэрсийг нийтэлж байгаа. Ингэснээр өртэй татвар төлөгчдийн нэр төрийг сэвтүүлж хохирол учруулснаар жагсаалтаас нэрээ хасуулахын тулд татварын өрөө төлөхөд хүргэж болзошгүй. Оршин суугаа хаяг болон хөрөнгийн мэдээлэл нь олдохгүй байгаа татвар төлөгчийн талаарх мэдээллийг олон нийтээс сайн дураар цуглуулах ба мэдээллээр хангагч нарыг мөнгөөр урамшуулдаг байна. Тухайн жагсаалтад овог нэр, төрсөн огноо, эсхүл хуулийн этгээд байгуулсан огноо, хуулийн этгээдийн хувьд хувь нийлүүлэгчдийн нэрс, татвар төлөгчийн дугаар, хамгийн сүүлд мэдэгдэж буй хаяг, хамгийн сүүлд мэдэгдэж байсан орлогын эх үүсвэр, татварын өрийн тогтоосон огноо, өрийн хэмжээ, ямар ангилалд хамаарах эсэх (хөрөнгөгүй, өр барагдуулахад хангалттай хөрөнгөгүй, байршил тогтоож чадаагүй гэх гурван ангилал бий), тухайн татвар төлөгчийн

талаарх мэдээллийг хүлээн авах харьяа татварын албын мэдээллийг тусгасан байдаг.

БНСУ 2004 оноос хойш өртэй татвар төлөгчдийн нэрсийн жагсаалтыг татварын алба цахим хуудаастаа нийтэлж байгаа бөгөөд татварын өр үүсээд хоёр жил өнгөрсөн 1 тэрбум воноос дээш өртэй татвар төлөгчийн мэдээллийг нийтэлдэг байсан. 2017 оноос хойш Улсын татвар хураах тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 114.1-д зааснаар татварын өр үүссэнээс хойш нэг жилийн хугацаа өнгөрсөн, 200 сая вон ба түүнээс дээш татварын өртэй татвар төлөгчийн хувийн мэдээлэл болон өрийн хэмжээг нийтэд ил болгодог. Татварын өрийн хэмжээ эцэслээгүй, маргаантай байгаа бол нийтэд дэлгэхгүй.

Их Британид татвар төлөгчдийн санаатайгаар татвар төлөхгүй байх сэдлийг бууруулах, хувь хүн болон аж ахуйн нэгжийг санаатайгаар татвар төлөх үүргээ биелүүлэхгүй байхыг таслан зогсоох үүднээс санаатайгаар татвараа төлөөгүй татвар төлөгчдийн мэдээллийг дэлгэх арга хэмжээг хэрэгжүүлж байна. Татвар төлөгч нь санаатайгаар татварын өрөө төлөөгүй байх нь өртэй татвар төлөгчдийн жагсаалтад орохыг шийдэх хамгийн чухал шалгуур болно. Санаатайгаар татвар төлөөгүй эсэхийг тогтоох нь төвөгтэй ба санаатай үйлдэл, эсхүл санаатайгаар нуун дарагдуулсан үйлдэлдээ торгууль хүлээсэн этгээд мөн үү гэдгийг онцлон шалгана. Санаатайгаар татварын өрөө төлөөгүй этгээдийг олон нийтэд дэлгэх ажлыг тусгай мэргэшсэн баг хариуцах ба өртэй татвар төлөгч бүрийн кейс дээр нэг бүрчилсэн шалгалт явуулна. Уг шалгалтын үеэр татвар төлөгч хувь хүн, аж ахуйн нэгж нь хууль бус үйлдлээ хүлээн зөвшөөрөх эсхүл шаардлагатай мэдээллээр хангаж татварын шалгалтад туслалцаа үзүүлбэл хариуцлагаас хөнгөлөгдөх боломжтой. Тусгай мэргэшсэн баг нь тодорхой таван асуултад “тийм” гэх хариулт өгснөөр татвар төлөгчийн дэлгэрэнгүй мэдээллийг нийтэд дэлгэх урьдчилсан нөхцөл бүрдэнэ. Дээрх таван асуултын хариулт нь бүгд “тийм” гэж хариулсан ч зарим онцгой тохиолдолд тухайн татвар төлөгчийн хувийн мэдээллийг дэлгэхгүй байх нь бий. Тодруулбал, явагдаж буй эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулах болон тухайн этгээдийн аюулгүй байдалд ноцтой бөгөөд бодитой хохирол учруулахаар бол хувийн мэдээллийг нийтлэхгүй. Тэдний зүгээс татвар төлөгчдийн нэрсийг олон нийтэд дэлгэхээс өмнө тухайн татвар төлөгчид рүү мэдэгдэл илгээж, өөрийнх нь хувийн мэдээллийг олон нийтэд дэлгэхгүй байх талаар 30 хоногийн дотор тайлбар хийх боломжийг олгодог. Өөрөөр хэлбэл, тухайн татвар төлөгч нь өөрийнх нь нэрийг санаатайгаар татвар төлөөгүй этгээдийн нэрсийн жагсаалтад тусгуулахгүй байх үндэслэлийг гаргаж тавих боломжтой.

АНУ-ын хэмжээнд өртэй татвар төлөгчдийн жагсаалтыг дэлгэх нь түгээмэл байна. Үүнээс зарим мужийн эрх зүйн зохицуулалт болоод



жагсаалтын онцлогийг дурдвал: Оклахома муж, 25.000 доллароос давсан татварын өртэй, үүнтэй холбогдох давж заалдах гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа дууссан, татварын баталгаа гаргаснаас хойш 90 хоногийн дотор төлбөрөө барагдуулаагүй бүх татвар төлөгчдийн нэрсийн жагсаалтыг бэлтгэн хадгална. Үүнээс хамгийн их өртэй 100 татвар төлөгчдийг тусад нь жагсаадаг. Ийнхүү жагсаалтыг дэлгэхээс өмнө тухайн татвар төлөгчид хандан 90 хоногийн дотор төлбөрөө төлөх, эсхүл төлбөр төлөлтийн тохиролцоо байгуулахыг санал болгодог. Түүнчлэн татвар төлөгчийн нэр жагсаалтад орохын тулд тухайн татварын өр хөдөлгөөнгүй болсон буюу маргаангүй эцсийн байх ёстой. Калифорния муж, татварын албанаас улирал бүр 100.000 доллароос давсан хамгийн их татварын өртэй 500 татвар төлөгчийн мэдээллийг нийтэд ил болгоно. Энэ нь өмнөх АНУ-ын бусад мужтай адилхан, татварын өрийн хэмжээ эцсийнх бөгөөд давж заалдах гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа дууссан ба жагсаалтад нэрийг оруулахаас өмнө тухайн татвар төлөгчид урьдчилан мэдэгдсэн байхыг шаарддаг. Нью-Йорк муж, хамгийн их татварын өртэй 250 хувь хүн, аж ахуйн нэгжийн жагсаалтыг олон нийтэд дэлгэнэ. Үүндээ татвар төлөгчийн нэр, татварын төрөл, татварын баталгааны дугаар, өрийн хэмжээ, өрийг тогтоосон огноо, аль дүүрэг болохыг оруулдаг. Дээрх татварын баталгаа нь татварын барьцаа, шүүхийн шийдвэр гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, татварын өрийн хэмжээ нэгэнт тодорхой болж маргаангүй болсон үед татварын алба буюу захиргааны байгууллагаас шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эхэнд үйлдэх баримт бичиг юм. Үүнийг илгээхээс өмнө татвар төлөгчид мэдэгдэх бөгөөд сонсох ажиллагаа хийх боломжийг бас олгох ёстой. Колорадо муж, татварын өрийн хэмжээ тодорхой болсноос 6 сар өнгөрсөн, торгууль, хүү болон татварын үндсэн төлбөрийн нийт хэмжээ 20.000 доллароос хэтэрсэн татварын өртэй этгээдийн мэдээллийг жагсаалтад оруулна. Уг жагсаалтад овог нэр, гэрийн хаяг, татварын төрөл, албан ёсоор таслан сэргийлэх баталгаа гаргасан огноо, үлдсэн өр, аж ахуйн нэгжийн хувьд бүртгэл дээр ерөнхийлөгчийн нэрийг тусгасан. Мөн адил 90 хоногийн өмнө мэдэгдэнэ. Татварын өрийн хэмжээ эцэслээгүй буюу маргаантай байгаа болон татварын алба ба татвар төлөгч нар хоорондоо татварын өр төлөлтийн төлөвлөгөө тохиролцсон бол татвар төлөгчийн мэдээллийг олон нийтэд ил болгохгүй.

Өртэй татвар төлөгчдийн нэрсийн жагсаалтыг дэлгэх арга хэмжээний үр нөлөөний талаар 2015 онд АНУ-д анх удаа өртэй татвар төлөгчийн нэрсийн жагсаалтыг дэлгэх буюу тэднийг ичээх арга нь татвар төлөлтөд хэр үр нөлөө үзүүлж буйг эмпирик судалгааны үндсэн дээр тодруулжээ. ... Судалгааны дүнгээс харахад ичээх арга буюу өртэй татвар төлөгчийн нэрсийг нийтэд дэлгэх нь бага хэмжээний өртэй татвар төлөгчид илүү үр дүнтэй, ерөө төлөхийг сэдэлжүүлж өр төлөлтийн үзүүлэлтийг нэмэгдүүлсэн. Эсрэгээрээ их хэмжээний өртэй татвар төлөгч нарын хувьд ичээх арга нь үр дүнгүй гэдэг нь нотлогдсон байна. Уг судалгааны дүнд

өртэй татвар төлөгчдийн нэрсийг нийтэд ил болгохыг бүрэн үгүйсгээгүй ба тухайн хувь татвар төлөгч өөрөө нийгмийн эсрэг үйлдлээсээ ичих, нийгмийн харилцаа болон өөрийн нэр хүндээ хэр чухалчилдаг болохоос хамаарч хүн бүрд үзүүлэх нөлөөлөл нь харилцан адилгүй байж болно.

Их Британид 2017 онд явуулсан хэрэгжилтийн үнэлгээний социологийн судалгаанаас үзэхэд олон нийтийн дунд өртэй татвар төлөгчдийн нэрсийн жагсаалтыг нийтлэх талаарх ойлголт 28 хувьтай бөгөөд татварын албаны зүгээс татвар төлөгчдийн эрхэнд халдах бусад төрлийн төрийн оролцооны хэлбэртэй харьцуулахад хамгийн бага нөлөөлөл үзүүлж байгаа болохыг тогтоожээ. Тодруулбал, нэрс нь олон нийтэд дэлгэгдсэн татвар төлөгчдийн хувьд энэ төрлийн арга хэрэгсэл нь үр дүн бага байна. Олон нийтийн зүгээс энэ төрлийн арга хэрэгсэл нь татвараа төлөхгүй байхаас зайлсхийхэд 59 хувь, татвараа ахин төлөхгүй байхад 57 хувиар хүчтэй буюу тодорхой хэмжээгээр эергээр нөлөөлнө гэж үзэж байгаа. Судалгаанд оролцсон зорилтот бүлгээс өртэй татвар төлөгчдийн нэрсийн жагсаалтыг нийтлэх арга хэмжээг татвараас зайлсхийхтэй тэмцэх үр дүнтэй арга хэрэгсэл болгохын тулд бизнес эрхлэхэд тохиромжтой үйлчлүүлэгч болон ханган нийлүүлэгч эсэхийг шалгахад энэхүү жагсаалтыг ашиглах, орон нутгийн сонин болон арилжааны хэвлэлд уг жагсаалтыг нийтэлж олон нийтэд илүү хүртээмжтэй болгох талаар саналыг өгчээ.

Дээрхээс дүгнэхэд улс орон бүрд татварын тайлагналыг нэмэгдүүлэх, татварын өр төлөлтийг сайжруулах, эсхүл татварын мэдээллийг нээлттэй байршуулах замаар иргэдийн татварын ухамсрыг нэмэгдүүлэх гэх мэт янз бүрийн зорилгоор өртэй татвар төлөгчдийн хувийн мэдээллийг агуулсан жагсаалтыг нийтэд ил болгож байна. Улсуудын туршлагаас харахад өртэй татвар төлөгчдийн нэрсийн жагсаалтыг дэлгэхдээ дараах зүйлсийг онцлон анхаарч байна: татварын өр үүссэнээс хойш хэдий хугацааны дараа татвар төлөгчийн хувийн мэдээллийг дэлгэх буюу татварын өрийн насжилт; хэдий хэмжээний татварын өртэй бол тухайн татвар төлөгчийн нэрсийг дэлгэх буюу татварын өрийн хамгийн доод хязгаар; жагсаалтыг дэлгэхээс өмнө тухайн татвар төлөгчид урьдчилан мэдэгдэж, жагсаалтад тусгах мэдээлэл үнэн зөв эсэхийг нягтлуулах буюу жагсаалтад орох мэдээллийн үнэн зөв байдлын баталгаа; өртэй татвар төлөгчид тодорхой хугацаанд өрөө төлөх боломжийг санал болгох; жагсаалтад орох мэдээллийг өртэй татвар төлөгчийн хувьд хамгийн бага байлгаж, зөвхөн шаардлагатай мэдээллийг тусгах; татварын өрийн хэмжээ нь эцэслэн тогтсон буюу давж заалдах гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа бүрэн дууссан, дампуурлын хэрэг үүсгээгүй татварын өр байх ёстой.



Өртэй татвар төлөгчийн нэрсийг нийтэд дэлгэснээр тухайн этгээдэд шинээр хариуцлага хүлээлгэх эсэх тухайд олон нийтийн дунд аливаа иргэн, аж ахуйн нэгжийг татвараа хугацаанд нь төлөөгүй гэдгийг зарласнаар ямар ч эрх зүйн хариуцлагыг ахин хүлээхгүй. Гэсэн хэдий ч өртэй татвар төлөгчийн нэр нийтэд ил болсноор огт хариуцлага хүлээхгүй гэвэл худал юм. Мэдээж хэрэг татварын өрөө төлөх үүрэг хэвээр байна. Тухайн татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгж нь нийгмийн нэг гишүүн болохынхоо хувьд нийтийн зардлаас өөрийн чадавхад нийцүүлэн хамтран үүрэх ёстой атал үүнийгээ умартсан. Иймээс тухайн өртэй этгээд нь олон нийтийн зүгээс зэмлэл хүртэх, нийгмээс шахагдах, ялгаварлан гадуурхагдах, доромжлолд өртөх, бизнесийн хамтрагч болон үйлчлүүлэгчээ алдах, нийгмийн дунд бий болгосон өөрсдийн дүр төрхөө алдах зэрэг шууд бус сөрөг үр дагавар олон үүснэ. Энэ мэтчилэн нийгэм дотроос урган гарах нийгмийн хариуцлага яригдах учиртай.

*3.Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1 дэх заалтад “мэдээллийг татварын албаны шаардсанаар тухай бүр” банк, бусад санхүүгийн эрх бүхий байгууллагаас гаргуулж авахаар заасны “шаардсанаар” гэсэн нэр томъёог хэрхэн ойлгож хэрэглэж байгаа, уг хуулийн 34.4.3 дахь заалтад “албан бичгээр гаргасан хүсэлт” гэж тусгаснаас ямар ялгаатай болох талаарх судалгаа:* (ямар үндэслэл, шалгуур хангасан тохиолдолд гаргах талаарх мэдээлэл)

Татварын ногдлыг тодорхойлох болон татвар хураах үүднээс татварын албанд татвар төлөгчийн талаарх нэмэлт мэдээлэл болон баримт бичиг шаардлагатай болдог. Энэ тохиолдолд татварын алба нь Татварын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар мэдээлэл агуулж байгаа байр агуулах, баримт материал, компьютер зэрэгт бүрэн нэвтрэх; мэдээлэл болон баримт бичгийг шаардах; тодорхой газар болон хугацаанд мэдээлэл авахаар дуудан ирүүлэх замаар шаардлагатай мэдээлэл болон баримт бичгээ олж авах боломжтой. Үүнээс “мэдээлэл болон баримт бичгийг шаардах” гэдэг нь Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1 дэх заалтад “мэдээллийг татварын албаны шаардсанаар тухай бүр”, мөн хуулийн 34.4.3 дахь заалтад “албан бичгээр гаргасан хүсэлт” гэх нэр томъёотой шууд холбогдох юм. Энд дурдагдаж буй шаардах гэдэгт юуг ойлгох, албан бичгээр, цахим шуудангаар, утсаар, цахим системээр буюу ямар хэлбэрээр шаардах талаар тодорхойгүй байна.

Татварын алба нь шаардлагатай мэдээлэл болон баримт бичгийг ямар арга, хэлбэрээр шаардах талаар Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/263 дугаар тушаалаар баталсан Татварын ногдлыг тодорхойлох, татвар хураах зорилгоор хэрэгжүүлэх нийтлэг ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах журмаар илүү нарийвчлан зохицуулсан. Тус журмын 4 дэх заалтын 4.2-т “Татварын алба ... байр агуулахад



нэвтрэлгүй уг этгээдийг дуудан ирүүлэх болон харилцаа холбооны хэрэгсэл, цахим систем ашиглан мэдээ, мэдээлэл, баримт гаргуулан авсан тохиолдолд ... томилолтгүйгээр гүйцэтгэж болно.” гэж заажээ.

Үүнээс үзвэл татварын алба нь шаардлагатай мэдээлэл болон баримт бичгийг олж авах зорилгоор нэгдүгээрт, холбогдох этгээдийг дуудан ирүүлэх, хоёрдугаарт, харилцаа холбооны хэрэгсэл, цахим систем ашиглан гаргуулан авах гэх хоёр аргыг ашиглахаар байна.

Эдгээрээс дуудан ирүүлэх тухайд, Татварын ерөнхий хуулийн 79 дүгээр зүйлийн 79.4.13 дахь заалтад зааснаар “зарлан дуудах хуудас” үйлдэж, дуудан ирүүлснээр хэрэгцээт мэдээлэл болон баримт бичгээ гаргуулан авна. Үүнээс өөрөөр гар утсаар, цахим шуудангаар ч бас шаардлагатай мэдээлэл болон баримт бичгийг шаардаж болох нь Татварын ногдлыг тодорхойлох, татвар хураах зорилгоор хэрэгжүүлэх нийтлэг ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах журмын 4 дэх заалтын 4.2-т зааснаас ойлгогдож байгаа. Иймд татварын албанаас санхүүгийн эрх бүхий байгууллагын холбогдох этгээд рүү цахим шуудангаар, гар утсаар хандан мэдээлэл шаардахыг үгүйсгэхгүй. Гэхдээ татварын алба нь арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон бусад санхүүгийн эрх бүхий байгууллагаас татвар төлөгчийн дансны мэдээлэл зэргийг тогтоосон хугацааны дотор гарган өгөхийг үүрэг болгох тул захиргаанаас гадагш орших хувийн эрх зүйн хуулийн этгээдэд чиглэж, заавал биелүүлэх шинжтэй үүргийг шинээр үүсгэнэ. Ийм учраас Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт зааснаар татварын алба нь татвар төлөгчийн мэдээллийг шаардах үедээ зайлшгүй бичгэн хэлбэртэй захиргааны акт үйлдэх ёстой. Гэсэн хэдий ч бичгээр шаардахаар бол ямар загвартай баримт бичиг үйлдэх талаар татварын байцаагчийн үйлдэх баримт бичгийн төрлийн жагсаалтад тусгаагүй учраас бичгээр мэдээлэл болон баримт бичгийг шаардах үед хэрэглэх баримт бичгийн тогтсон загвар байхгүй.

Эдгээрээс дүгнэхэд Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1 дэх заалтад “шаардсанаар” гэх ойлголтод мэдээллийг ямар хэлбэрээр шаардахыг заагаагүй, энэ тохиолдолд цахим систем, цахим шуудан, эсхүл утсаар шаардсаныг ч ойлгож болно. Харин мөн хуулийн 34.4.3 дахь заалтад “албан бичгээр гаргасан хүсэлт” гэдэгт мэдээлэл шаардах хэлбэрийг бичгэн байна гэж тодорхой зааснаар ялгаатай байна. ...” гэжээ.

***Долоо. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд бэлтгэх хүрээнд холбогдох баримт бичиг, тайлбар, дүгнэлт, шийдвэртэй танилцсан болно.***

Жишээлбэл, НҮБ-ын Хүний эрхийн хорооны ерөнхий тайлбар (№16, §17, 20.): Хувийн халдашгүй байх эрх, Үндсэн хууль манай сургуульд: НҮБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар болон сургалтын хөтөлбөр (МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, 2022);

Нидерландын эсрэг Корийл, Аурик, НҮБ-ын Хүний эрхийн хороо, Мэдээлэл No.453/1991 (Coeriel and Aurik v. Netherlands, U.N. Human Rights Committee, Communication No.453/1991, HRC 1995 Report, Annex X.D.)

### ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 7 дахь заалтад заасан онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурал Татварын ерөнхий хуулийг 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн байна. Уг хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно.” гэж, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсэгт “Арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон бусад санхүүгийн эрх бүхий байгууллага дараах мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:” гээд 34.4.1 дэх заалтад “татвар төлөгчийн дансны мэдээлэл болон уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээллийг татварын албаны шаардсанаар тухай бүр,”; 34.4.3 дахь заалтад “татвар төлөгчийн дансны гүйлгээний мэдээллийг татварын албанаас бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг үндэслэн.” гэж заажээ.

Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсгийн 34.4.1, 34.4.3 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хууль (цаашид “Үндсэн хууль” гэх)-ийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтыг зөрчсөн гэх мэдээллийг иргэд гаргаж маргаан үүсгэсэн. Иймд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын “халдашгүй, чөлөөтэй байх эрх”-ийн агуулгыг тодорхойлж, Татварын ерөнхий хуулийн дээрх заалт тус бүрийг уг агуулгад нийцсэн эсэхийг авч үзлээ.

Нэг. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын “халдашгүй, чөлөөтэй байх эрх”-ийн агуулгын тухайд:

1.1. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх



чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална,” гэж тусгажээ. Тус заалтаар хүний “халдашгүй, чөлөөтэй байх эрх”-ийг хамгаалж, энэ хүрээнд “хүний нэр төр халдашгүй байх, эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий, доромж хандлагаас ангид байх туйлын эрхээс гадна бие махбодын болон бусад эрх чөлөө /хувийн халдашгүй байх, гэр бүл халдашгүй байх, захидал харилцааны нууц халдашгүй байх, орон байр халдашгүй байх зэрэг эрх/, тэдгээрийг хязгаарлахад тавих нөхцөлийг тогтоож баталгаажуулсан ...” гэж Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлт (12 дахь тал)-д энэхүү эрхийн хүрээг өргөн агуулгаар тайлбарласан.

1.2.Хувийн халдашгүй байх эрх нь хүний хувийн амьдралд үндэслэлгүйгээр халдахаас хамгаалах бөгөөд бусад хүний эрх, эрх чөлөөнд саад учруулалгүйгээр, бусдын хараа хяналтаас ангид, хүсэл зоригийнхоо дагуу амьдралаа удирдан зохицуулах агуулгатай. Тодруулбал, хувийн халдашгүй байх эрх нь хувийн мэдээлэл халдашгүй байх, бусдын хараа хяналтаас ангид өөрийнхөөрөө чөлөөтэй байх, өөрийн онцлог шинжийг чөлөөтэй илэрхийлэх, бусадтай хувийн харилцаа тогтоох, хувийн амьдралтайгаа холбоотой сонголт хийх зэрэг эрх чөлөөг багтаадаг.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын “халдашгүй, чөлөөтэй байх эрх”-ийн хүрээнд хувийн мэдээлэл халдашгүй байх эрх хамгаалагдана. Хувийн мэдээлэл гэдэгт тухайн хүний хувийн амьдралд нь хамаарах мэдээллийг буюу түүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой мэдээллийг хамруулан ойлгоно. Хувийн мэдээлэл халдашгүй байх эрх нь хүн өөрийн хувийн мэдээллийг нийтэд дэлгэх эсэх, хэзээ, ямар хэмжээгээр дэлгэхээ шийдэх, мөн хувийн мэдээллийг хязгааргүйгээр цуглуулах, хадгалах, боловсруулах, ашиглах, бусдад дамжуулахаас хамгаалуулах зэрэг агуулгатай. Түүнчлэн энэ эрхийн хүрээнд мэдээллийн урсгалын аюулгүй байдал хамаарах бөгөөд зохих зөвшөөрөлгүй, хууль бус хяналт шалгалтаас ангид байх, урьдчилан сэргийлэх боломж, нөхцөлөөр хангагдсан байна. Хүн хувийн мэдээллээ хэн, хэзээ, хэрхэн цуглуулах, боловсруулах, ашиглахыг чөлөөтэй шийдэх эрхтэй байх нь өөрийгөө тодорхойлох, таниулах болон хүний нэр төрийг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой.

Хувийн мэдээллийг нь төр хамгаалж, санаатай болон санамсаргүй дур мэдэн нийтэд дэлгэхгүй гэсэн зүй ёсны хүлээлттэйгээр татвар төлөгч татварын тогтолцоонд итгэж, хуулийн дагуу хүлээсэн татвар төлөх үүргээ биелүүлдэг. Зохих нууцлалтай гэсэн итгэлд үндэслэн төрийн үйлчилгээг



авахдаа иргэн өөрийн хувийн мэдээллээ төрийн байгууллага, бусад этгээдэд шилжүүлэн өгдөг тул хувийн мэдээлэл халдашгүй байх эрхийн дагуу төр, бусад этгээдийн зүгээс иргэний хувийн мэдээллийг тухайн иргэний зөвшөөрөлгүй эсхүл хуульд заасан үндэслэлгүйгээр бусдад өгөх, ашиглуулах, нийтэд дэлгэхийг хязгаарлана. Төрд байгаа хувийн мэдээллийг бусдад дамжуулах, нийтэд дэлгэхэд төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай өөр төрлийн мэдээлэл солилцоход тавигдах шалгуураас илүү өндөр байх нь зүй ёсны юм.

Мэдээллийн технологийн хөгжил хувийн мэдээллийг олж авах, цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, дамжуулах ажиллагааг хялбар болгосон нь хүний хувийн мэдээллийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр дамжуулах, боловсруулах, тухайн хүний онцлог шинж, зан байдлыг тодорхойлоход ашиглах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

1.3. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын “халдашгүй, чөлөөтэй байх эрх”-ийн хүрээнд хүний нэр төр, алдар хүндийг хамгаалдаг бөгөөд эдгээрийг Үндсэн хуулийн бусад заалтаар мөн хүлээн зөвшөөрсөн. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “... Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. ...” гэж, мөн зүйлийн 17 дахь заалтад “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;” гэж, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад Монгол Улсын иргэн “хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;” үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ гэж тус тус заасан.

Үндсэн хуулийн Оршилд зарлан тунхагласан хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилго нь Монгол Улсад хүн бүрийг хувь хүн гэж хүлээн зөвшөөрч, хүний нэр төрийг нь хүндэтгэх, үүний тулд үндсэн эрхийг нь баталгаатай эдлүүлэхийг төрд үүрэгжүүлсэн утга агуулдаг. Хүний нэр төр нь хүн болохын хувьд угаас чухал үнэ цэнтэй гэж хүлээн зөвшөөрч хүндэтгэх үүргийг төрд хүлээлгэж, хүн эрх зүйн этгээд байхыг хамгаалдаг. Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж тодорхой заасан нь хүнийг нийгмийн харилцааны объект бус, субъект гэж хандана гэсэн үг.

1.4. Үндсэн хуулийн дээрх заалтад байгаа хүний нэр төр, алдар хүнд гэсэн ойлголтын ялгааг тодорхойлох нь тэдгээрийг зөв хэрэглэж, хамгаалахад ач холбогдолтой. Монгол Улс Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал /цаашид “Тунхаглал” гэх/-ын Оршил, 1 дүгээр зүйл, 22 дугаар

зүйлд “dignity” гэснийг “нэр төр” гэж, харин 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “dignity” гэснийг “хүний зэрэгтэй” гэж, Тунхаглалын 12 дугаар зүйлд “honour and reputation” гэснийг “нэр төр, алдар хүнд” гэж, түүнчлэн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын Оршил болон 10 дугаар зүйлд дурдагдсан “dignity”-ыг “нэр төр” гэж, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “honour and reputation” гэдгийг “нэр төр, алдар хүнд” гэж, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн а/ заалтын “reputation” гэдгийг “нэр төр” гэж тус тус орчуулжээ. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын Оршил болон 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “dignity” гэснийг “нэр төр” гэж хөрвүүлсэн байна. Эндээс үзвэл “dignity,” “honour and reputation,” “reputation,” гэх ялгаатай ойлголтуудыг янз бүрээр, ялангуяа хооронд нь хольж адил үгээр томъёолж байгаа нь эдгээр ойлголтын ялгааг бүрхэгдүүлж, төөрөгдөл үүсгэх эрсдэлтэй байна. Иймээс Үндсэн хуулийн агуулгад нийцүүлэн “dignity”-ыг “нэр төр”, “honour and reputation” гэснийг “алдар хүнд” гэж томъёолж хэвших нь зүйтэй байна. Тухайлбал, алдар хүнд нь хүний нэр төрөөс ялгаатай бөгөөд ёс суртахууны, мэргэжлийн эсхүл бусад хэмжүүрээр хувь хүн нийгэмд ямар байр суурь эзэлж буйг харуулна. Мөн олон улсын хүний эрхийн эрх зүй дэх “honour and reputation” гэх нэр томъёо нь тухайн хүний нийгэмд эзэлж буй байр суурийг илэрхийлдэг. Энэ хоёр ойлголтыг ялгаж хэрэглэх шаардлага төдийлөн байхгүй ч ийнхүү ялгах тохиолдолд “reputation” нь дангаараа тухайн хүний нийгэмд эзэлж буй байр суурийг илэрхийлэх өргөн утгатай тул “алдар хүнд” гэх үгээр илэрхийлэх боломжтой.

1.5. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтаар баталгаажсан хувийн мэдээлэл болон алдар хүнд халдашгүй байх эрх нь туйлын эрх биш тул Үндсэн хуулийн дагуу хязгаарлагдаж болно. Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хууль дээдлэх болон шударга ёсны зарчмын дагуу үндсэн эрхийн хязгаарлалт нь хуульд тодорхой заасан байх, тохирсон байх, шүүхийн хяналтад байх зэрэг зарчмыг хангах шаардлагатай бөгөөд эдгээр зарчмын аль нэгийг хангаагүй бол тухайн хязгаарлалт үндсэн эрхийг зөрчсөн гэх үндэслэл болно. (Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр тогтоол, Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлт)

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “... Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ...” гэж заасан. Энэ заалтын дагуу эрх чөлөөнд тавих хязгаарлалт нь хуульд заасан үндэслэл, журамтай байх төдийгүй дур мэдсэн байж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур эрх чөлөөг хязгаарлах нь дур мэдсэнд тооцогдоно. Түүнчлэн хуулиар зөвшөөрөгдсөн хязгаарлалт ч дур мэдсэн шинжтэй байж болно. “Дур мэдэн” гэх ойлголт нь зөвхөн “хууль зөрчсөн” гэсэн ойлголтоор хязгаарлагдахгүй харин шударга бус, урьдчилан таамаглах боломжгүй, зохих журмыг баримтлаагүй,



үндэслэлгүй, тохирсон бус гэх зэрэг илүү өргөн хүрээнд тайлбарлагдах бөгөөд нийтийн албан тушаалтны дур мэдэл, үзэмжээс ангид байх гэсэн утгатай.

1.6. Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасан тул Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (цаашид “Пакт” гэх)-аар хүлээсэн үүргээ Монгол Улс шударгаар сахин биелүүлнэ. Пактын 17 дугаар зүйлд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл ... алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно. Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй.” гэж хувийн халдашгүй байх эрхийг баталгаажуулсан. Пактын 17 дугаар зүйлийн хувийн халдашгүй байх эрхийг НҮБ-ын Хүний эрхийн хороо (Мэдээлэл No.453/1991) өргөн агуулгаар тайлбарласан бөгөөд хувийн халдашгүй байдал (privacy) нь хүн дангаараа эсхүл бусадтай харилцах замаар өөрийн онцлог шинжийг чөлөөтэй илэрхийлэх хувийн амьдралын хүрээ юм.

НҮБ-ын Хүний эрхийн хорооны 16 дугаар Ерөнхий тайлбар (догол 10)-т хувийн халдашгүй байх эрхийг хүний хувийн амьдралыг хууль бус халдлагаас хамгаалах гэсэн өргөн агуулгаар тайлбарласны зэрэгцээ “Хүний хувийн амьдралын мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах эрх хуулиар олгогдоогүй этгээд уг мэдээллийг олж авах, Пактад үл нийцэх байдлаар ашиглахгүй байх баталгааг бүрдүүлэх үр дүнтэй арга хэмжээг улс орнууд авна. Хувийн амьдралаа үр дүнтэй хамгаалахын тулд өөрт холбоотой мэдээлэл автомат санд байршиж байгаа эсэх, ямар төрийн байгууллага, хувь хүн, нийгмийн бүлэгт ямар зорилгоор хадгалагдаж байгаа эсэхийг мэдэх, нягтлах эрхтэй. Мөн хувийн мэдээлэл алдаатай, түүнийг хууль бус аргаар цуглуулсан, боловсруулсан тохиолдолд хүн бүр уг мэдээлэлд засвар хийх, устгуулах хүсэлт гаргах эрхтэй.” гэж тусгайлан тэмдэглэсэн. Иймээс хувийн мэдээлэл халдашгүй байх эрхийг хувийн халдашгүй байх эрхэд багтааж, ийм өргөн агуулгаар баталгаажуулж, хамгаалах үүргийг Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээж байна.

Хоёр. Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын холбогдох зохицуулалтыг зөрчсөн эсэх тухайд:

Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль



тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно.” гэж заасан. Ийнхүү хуульчилсан нь татварын хууль тогтоомж зөрчсөн бөгөөд хуульд заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, татварын хууль тогтоомж зөрчсөн бөгөөд нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан болон эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаарх мэдээлэл (сөрөг)-ийг тэдний зөвшөөрөлгүйгээр төр буюу татварын алба нийтэд мэдээлэх нөхцөлийг үүсгэж байна.

Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад заасан халдашгүй, чөлөөтэй байх эрхэд хамаарах хувийн мэдээлэл болон алдар хүнд халдашгүй байх эрхийг хязгаарлах үр дагавартай байна. Тодруулбал, татварын хууль тогтоомжийг зөрчсөн татвар төлөгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлэх нь түүний зөрчил үйлдсэн тухай хувийн мэдээллийг нийтэд дэлгэх төдийгүй тухайн татвар төлөгчийн нийгэмд эзлэх байр суурьд сөргөөр нөлөөлөх тул алдар хүндэд нь халдах хэлбэр болно. Татварын хууль тогтоомжийг зөрчсөн гэдэг нь тухайн хүний хувийн мэдээлэлд хамаарах тул түүнийг бусдад дэлгэх нь хувийн мэдээлэл халдашгүй байх эрхийн хязгаарлалт юм. Харин татварын хууль тогтоомжийг зөрчсөн татвар төлөгчийн талаар өөрийнх нь зөвшөөрөлгүй нийтэд мэдээлэх нь түүний алдар хүнд халдашгүй байх эрхийг хязгаарлана. Ийм сөрөг агуулгыг нийтэд мэдээлэх нь тухайн татвар төлөгчийн хувьд ажил хэргийн харилцааны итгэлцэл, хамтран ажиллах найдвартай байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй. Харин гэмт хэрэг үйлдэх, татвар төлөхөөс оргон зайлах зэрэг үйлдэл нь санаатайгаар буюу өөрийн үйлдлийн үр дагаврыг татвар төлөгч урьдчилан таамаглаж хийсэн байдаг тул эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар татварын алба түүний зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлэх нь тухайн хүний хувийн мэдээлэл болон алдар хүнд халдашгүй байх эрхийн хамгаалалтад багтахгүй.

Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын дагуу хамгаалагдсан хувийн мэдээлэл болон алдар хүнд халдашгүй байх эрхийг тус тус хязгаарлах үр дагавартай байх тул тус зохицуулалт нь үндсэн эрхийн хязгаарлалтад тавих дээр дурдсан гурван зарчим (хуульд тодорхой заасан байх, тохирсон байх, шүүхийн хяналтад байх)-ыг хангасан эсэхийг шалгахад дараах нөхцөл байдал тогтоогдож байна:

2.1. Эрх зүйн тодорхой байдлыг хангасан эсэх тухайд:



Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон Арван зургадугаар зүйлд заасан хууль дээдлэх ёсны хүрээнд үндсэн эрхийг хязгаарласан хууль нь эрх зүйн тодорхой байдлыг хангасан буюу тодорхой байх зарчимд нийцсэн байхыг шаардана. Үндсэн эрхийн хязгаарлалтыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоосон байна. Өөрөөр хэлбэл, уг зарчим нь үндсэн эрхийн хязгаарлалт хууль ёсны үндэслэл бүхий байх бөгөөд хэрэгцээ шаардлага, зорилго, хэрэгжүүлэх журам, хязгаарлалтын цар хүрээг тодорхой тусгасан байхыг шаарддаг.

Эрх зүйн тодорхой байдлыг хангах хүрээнд (Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 02 дугаар дүгнэлт, мөн оны 02 дугаар тогтоол, 2020 оны 12 дугаар дүгнэлт, 2021 оны 02 дугаар дүгнэлт, 2024 оны 03 дугаар дүгнэлт) үндсэн эрхийг гагцхүү хуулиар хязгаарлах, уг хязгаарлалт нь хоёрдмол утгагүй, тодорхой ойлгогдохоор, зохицуулалтаас үүдэх үр дагаврыг урьдчилан таамаглаж, мэдсэнээр зан үйлээ нийцүүлэх боломжтой байдлаар хуульчлахыг шаарддаг болно. Ингэснээр хуулийг хэрэгжүүлэгч болон шүүх хуулийг нэг мөр хэрэглэх, эрх, эрх чөлөө нь тухайн хуулиар хязгаарлагдаж буй иргэн зан үйлээ хуульд нийцүүлэх нөхцөл бүрдэнэ. Мөн зөвхөн хуульд заасан үндэслэл гэдэгт хууль тогтоогчоос баталсан хуулиар хязгаарлалт тогтоохын зэрэгцээ тухайн хязгаарлалтыг үзэмжээрээ, дур мэдэн хэрэгжүүлэх боломжийг хязгаарласан (үндсэн эрхийг хязгаарлахыг зөвшөөрөх үндэслэл, журмыг хуульд нарийвчлан зааж, хязгаарлалтын цар хүрээг тогтоосон) байх ёстой.

Дээрх шалгуураар авч үзвэл, татварын хууль тогтоомжийг зөрчсөн татвар төлөгчийг нийтэд мэдээлэх талаарх зохицуулалтыг Татварын ерөнхий хуульд буюу уг хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт тусгасан нь үндсэн эрхийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлах шалгуурыг хэлбэрийн хувьд хангаж байх боловч уг үндэслэл, журмыг эрх зүйн тодорхой байдалд нийцүүлэн хуульчлаагүй байна. Тодруулбал, маргаан бүхий хуулийн заалтаар “татварын хууль тогтоомжийг зөрчсөн” байхын зэрэгцээ “хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй”, “нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан”, “эрэн сурвалжлагдаж байгаа” гэсэн нөхцөл бүрдсэн бол түүний мэдээллийг зөвшөөрөлгүй нийтэд дэлгэхээр хуульчилсан нь татвар төлөгчийн хувийн мэдээлэл халдашгүй байх эрхийг хязгаарлах үндэслэл болсон гэж үзэхээр байна.

Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “Татварын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.” гэжээ. Энэ хүрээнд чухам ямар хууль тогтоомжийн ямар заалтыг зөрчсөн тохиолдолд татварын хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзэх нь тодорхойгүй байна. Түүнчлэн хууль тогтоомжид заасан зөрчлөө

арилгаагүй гэсний зөрчил гэдэгт Татварын ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, эсхүл бусад хууль тогтоомжид заасан ямар үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгох, зөрчлийн мөн чанар, нийгмийн хор уршгийн хэр хэмжээг харгалзах эсэх нь тодорхойгүй байна.

Дээрх нөхцөл байдал үүссэн бол татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр түүний талаар нийтэд мэдээлж болохоор заахдаа нийтэд мэдээлэх мэдээллийн агуулга, хүрээ, мэдээлэх арга, хугацаа, мэдээллийн хэрэгсэл, зөрчлөө арилгасан бол мэдээллийг устгах эсэх, ийнхүү устгах нөхцөл, журмыг тодорхой тусгаагүй байх бөгөөд мэдээллийг дэлгэх эрх бүхий этгээдийг “татварын алба” гэж ерөнхий хуульчилсан байна. Тухайлбал, татвар төлөгчийн талаар нийтэд мэдээлэх гэдэгт ямар мэдээлэл багтаж байгаа болон уг татвар төлөгчийн нэр, хүйс, хаяг, эрхэлсэн ажил, албан тушаал, зөрчил, төлөгдөөгүй өр, бусад хувийн шинжтэй мэдээлэл агуулагдах эсэх нь тодорхойгүй, түүнчлэн татварын алба гэх нэр томъёоны хүрээнд татварын байцаагч бүр ийм эрх эдлэхээр ойлгогдож болохоор байна. Мөн “нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан” болохыг хэн хэрхэн тогтоох, хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэх эсэх нь тодорхойгүй буюу хуулиар зохицуулаагүй байна. Тодруулбал, ямар зөрчлийг хууль тогтоомжид заасан хугацаанд арилгаагүй гэж үзээд татвар төлөгчийн талаар нийтэд мэдээлэх болон ямар зөрчлийг “гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан” тохиолдолд татвар төлөгчийн талаар нийтэд мэдээлэх вэ гэдэг нь ойлгомжгүй байх бөгөөд энэ хоёр нөхцөл давхцах эсэх нь ч хуулийн зохицуулалтаас нэг мөр ойлгогдохгүй байна.

Маргаан бүхий хуулийн заалтад “нийтэд мэдээлж болно” гэж заасан нь дээр дурдсан урьдач нөхцөлийг бүгдийг хангаж татварын хууль тогтоомж зөрчсөн, улмаар оргон зайлж эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийг нийтэд мэдээлэх эсэхийг татварын албаны холбогдох албан тушаалтан өөрийн үзэмжээр шийдвэрлэх эрсдэлийг бүрдүүлжээ. Ийнхүү уг асуудлыг шийдвэрлэх эрхийг түүний үзэмжид үлдээсэн нь хуулийн дээрх зохицуулалтыг дур мэдэж, эсхүл ялгамжтай байдлаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, урвуулан ашиглах боломжийг үүсгэсэн гэж үзэхээр байна.

Дээр дурдсан нөхцөл байдал, үндэслэлээс дүгнэхэд Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн татвар төлөгчийн талаарх мэдээллийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлэхээр заасан холбогдох зохицуулалт нь эрх зүйн тодорхой байдлыг хангаагүй, улмаар үндсэн эрхийг зөвхөн хуульд тодорхой заасан үндэслэл, журмаар хязгаарлах талаарх Үндсэн хуулийн шаардлагад нийцэхгүй байна. Тодруулбал, Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт “Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, сангийн мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах, ашиглалтад хяналт тавих



журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.” гэж зааж, холбогдох харилцааг журмаар зохицуулахаар тусгажээ.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад мэргэжилтний тайлбарласнаар татварын хууль тогтоомжийг зөрчсөн гэдгийг Татварын ерөнхий хуулийг зөрчсөн бөгөөд хуульд заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй гэж явцуу хүрээнд авч үзсэн ч маргаан бүхий хуулийн заалтыг хэрэгжүүлэх хүрээ хязгаарыг хуульд нарийвчлан тусгаагүй байна. Иймд татвар төлөгчийн талаар өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлэх тухай хуулийн зохицуулалтыг ялгамж бүхий олон зорилгоор ашиглах орон зайг нээлттэй үлдээсэн байна. Маргаан бүхий хуулийн зохицуулалтыг тодорхой хуульчлаагүй нь уг харилцааны онцлогоос хамаарч хуулиар нарийвчлан тодорхой зохицуулахад бэрхшээлтэй байсантай холбоотой гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

## 2.2.Тохирсон байх зарчмыг хангасан эсэх тухайд:

Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйл болон Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын дагуу халдашгүй, чөлөөтэй байх үндсэн эрхийг хязгаарласан зохицуулалт нь тохирсон байх зарчимд нийцсэн байх шаардлагатай. Энэ зарчмын дагуу маргаан бүхий хуулийн заалтаар тогтоосон хязгаарлалт нь хууль ёсны зорилготой байх, уг зорилгод хүрэхэд чиглэсэн, зайлшгүй, тэнцвэртэй байх гэсэн дөрвөн шалгуурыг хангасан эсэхийг шалгахад дараах нөхцөл байдал тогтоогдож байна:

2.2.1.Үндсэн эрхийн хязгаарлалт буюу ийнхүү хязгаарлалт тогтоосон хуулийн зохицуулалт нь тохирсон байх ёстой бөгөөд энэ шалгуурт нийцэхийн тулд Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн хууль ёсны зорилготой байх учиртай. Хувийн мэдээлэл халдашгүй байх эрхийг нийтийн ашиг сонирхлын үүднээс хязгаарлах бөгөөд иргэний хувийн мэдээллийг зөвхөн хуульд нарийвчлан тусгасан тодорхой зорилгын хүрээнд ашиглана.

Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн “хуулиар ногдуулсан албан татвар төлөх;” үндсэн үүргийг ёсчлон биелүүлэхээр заасан бөгөөд Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалтад Засгийн газар “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;” бүрэн эрхтэй гэж заажээ. Татварын ерөнхий хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь Монгол

Улсад татвар бий болгох, тогтоох, татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах, хөнгөлөх, чөлөөлөх, суутган тооцох, буцаан олгох эрх зүйн үндсийг тогтоож, Монголын Татварын алба/цаашид "Татварын алба" гэх/, татвар төлөгч болон энэ хуулийн дагуу татварын албаны өмнө үүрэг хүлээсэн бусад этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино." гэж хуульчилжээ.

Татварын орлого нь төрийн халамж, үйлчилгээг иргэдэд үзүүлэх, эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах зэрэг салбар бүрээр төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр бөгөөд улсын нэгдсэн төсвийн дийлэнх хувийг бүрдүүлдэг. Татварын ерөнхий хуулийн маргаан бүхий зохицуулалт нь "хуулиар ногдуулсан албан татвар төлөх" иргэний үндсэн үүргийн хэрэгжилтэд хамаарах, татвар төлөгчийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэсэн төрийн үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хууль ёсны зорилготой, чухал ач холбогдол бүхий нийтийн ашиг сонирхолд үндэслэсэн гэж үзэхээр байна.

Хүний алдар хүндээ эрхэмлэх мөн чанартай нь холбогдуулан эрсдэлтэй буюу татвар төлөхөөс зугтдаг, татварын өр төлөхөөс зайлсхийдэг татвар төлөгчийн талаар нийтэд мэдээлэх зохицуулалтыг хуульчилсан нь хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгах сэдлийг нэмэгдүүлэх, татвар төлөхөөс зайлсхийх явдлыг таслан зогсоох зорилготой гэх үндэслэлтэй юм. Энэ хүрээнд Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад мэргэжилтний өгсөн тайлбарт "Нэмэгдсэн өртгийн албан татварын хий бичилттэй холбоотой асуудал дээр бид нар бусад татвар төлөгчид нь анхааруулах, урьдчилан сэргийлэх, цаашид гарах хор нөлөөллийг нь багасгах зорилгоор" хуулийн заалтыг хэрэгжүүлж байна гэснээс үзэхэд татвар төлөгчийг эрсдэлд оруулахгүй байх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хуулийн зохицуулалтыг практикт хэрэглэж байгаа гэж үзэхээр байна. Үүнээс үзэхэд маргаан бүхий зохицуулалт нь Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн хууль ёсны зорилготой байна.

2.2.2.Тохирсон байх зарчмын дагуу үндсэн эрхийн хязгаарлалт нь тухайн хууль ёсны зорилгыг биелүүлэхэд чиглэж, уг хязгаарлалт болон зорилго хоорондоо уялдсан байхыг шаардана. Хуульд тодорхой заасан урьдач нөхцөл бий болсон тохиолдолд татвар төлөгчийн талаар нийтэд мэдээлэх нь бусад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, татвар төлөгчийг эрсдэлээс сэргийлэх, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх болон хуулиар ногдуулсан албан татвар төлөх иргэний үндсэн үүргийг биелүүлэхэд чиглэсэн төрийн хууль ёсны зорилгод уялдсан байна. Түүнчлэн эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгч болон түүний санхүүгийн байдлын



талаарх ойлголтыг нийтэд мэдээлэх нь гуравдагч этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах боломжийг бүрдүүлнэ. Иймээс маргаан бүхий хуулийн зохицуулалтын дагуу хэрэгжүүлж буй арга хэмжээ нь зорилгодоо хүрэхэд чиглэсэн буюу уялдаатай байна.

2.2.3. Үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилгод хүрэхэд зайлшгүй байх шаардлагатай. Татварын хууль тогтоомж зөрчсөн татвар төлөгчийн талаар нийтэд мэдээлэхдээ зорилгодоо хүрэхэд шаардагдах хугацаанаас илүүгүй хугацаанд хадгалахаар хуульд тусгах нь хувийн мэдээлэл болон алдар хүнд халдашгүй байх үндсэн эрхийн хамгаалалтад нийцнэ. Гэтэл Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт заасны дагуу нийтэд мэдээлэхэд хугацааны хязгаар тогтоогоогүй байна. Хувийн мэдээллийг нийтэд дэлгэх болон алдар хүндэд халдах хуулийн үндэслэл үгүй болсноор ийнхүү нийтэд дэлгэсэн мэдээллийг устгах хуулийн хязгаарлалт тогтоож, уг эрхийн хамгаалалтыг хуульчлаагүй байна. Энэ нь тодорхойгүй хугацаагаар, хуульд заасан тодорхой нөхцөл, үндэслэл бий болоогүй эсхүл арилсан үед ч хувийн мэдээлэл болон алдар хүнд халдашгүй байх эрхийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлж, үндсэн эрхийн хязгаарлалт зайлшгүй байх зарчимд харшилжээ.

Ийнхүү эрхийн хязгаарлалтыг албан тушаалтны дур мэдэлд үлдээж, татвар төлөгчийн талаар ямар ч мэдээллийг нийтэлж болохоор, эсхүл урьдач нөхцөлийг хангасан ч нийтлэхгүй байж болохоор хэт өргөн хүрээтэй хязгаарласан, татвар төлөгчийн талаар нийтлэгдсэн мэдээлэл бодитой, үнэн зөв биш тохиолдолд мэдээлэлд засвар оруулах процессын хамгаалалтыг татвар төлөгчид олгоогүй, эрхийг хязгаарлах хуулийн үндэслэл, нөхцөл үгүй болсноор нийтэд дэлгэсэн мэдээллийг устгах хуулийн хязгаарлалт тогтоогоогүй зэрэг нь үндсэн эрхийн хязгаарлалт явцуу хүрээтэй байх, үндсэн эрхийг хамгийн бага хэмжээнд хязгаарлах зайлшгүй байх зарчимд нийцэхгүй байна.

Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллага татвар төлөхөөс зугтаж, оргон зайлсан татвар төлөгчийн хаягийг тогтоох, эрэн сурвалжлахад татварын албатай хамтарч ажиллана.” гэж заасан. Уг зохицуулалтаас үзэхэд татвар төлөхөөс зугтаж, оргон зайлсан татвар төлөгчийн хаягийг тогтоох, тодорхой мэдээлэл цуглуулах, улмаар төлөөгүй татварыг төлүүлэх зорилгоор эрэн сурвалжлах ажиллагааг явуулахаар байна. Иймд татвараа сайн дураар төлөхөөс зайлсхийж оргон зугтсан, хаяг нь тодорхойгүй татвар төлөгчийн талаарх мэдээллийг олон нийтээс авахын тулд маргаан бүхий зохицуулалтын дагуу нийтэд мэдээлж байгаа нь зүй ёсны үндэслэл бөгөөд зорилгодоо хүрэхэд зайлшгүй байх шалгуурт нийцсэн үндэслэл бүхий хэм хэмжээ болно.

2.2.4. Хувийн мэдээлэл халдашгүй байх эрхийг хязгаарласнаар хангагдах ашиг сонирхол нь уг эрхийг хамгаалах ашиг сонирхлоос дээгүүр байх тохиолдолд тухайн хязгаарлалт нь хууль дээдлэх ёсны үүднээс зөвтгөгдөх боломжтой. Тодруулбал, хууль ёсны бөгөөд чухал ач холбогдол бүхий нийтийн ашиг сонирхолд тодорхой аюул учруулж болохуйц үндэслэл бүхий нөхцөл байдал бүрдсэн тохиолдолд үндсэн хуулийн эрх зүйн үүднээс татвар төлөгчийн мэдээллийг нийтэд мэдээлэх замаар хувийн мэдээлэл халдашгүй байх үндсэн эрхийг хязгаарлах боломжтой.

Татвар төлөгчийн талаар өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлэхээр зааж, үндсэн эрхийг хязгаарласан маргаан бүхий хуулийн заалт нь өмнө дурдсан нийтийн чухал ашиг сонирхлыг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх төрийн нэн чухал чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна. Гэвч татвар төлөгч болон түүний гаргасан зөрчлийн талаар нийтэд мэдээлэх нь хувийн мэдээллийг нийтэд дэлгэж, алдар хүндэд нь ноцтой халдах арга хэрэгсэл мөн ч уг зөрчил нь адил түвшний ноцтой биш байж болохыг хуулийн зохицуулалтаар зөвшөөрсөн байна. Өөрөөр хэлбэл, ялимгүй зөрчлийг хуулийн хугацаанд арилгаагүй зэрэг тохиолдолд тухайн татвар төлөгчийн талаар нийтэд мэдээлэх (хувийн мэдээллийг нь нийтэд дэлгэх) замаар алдар хүндэд нь ноцтой халдах боломжтой байна. Энэ тохиолдолд нийтийн ашиг сонирхлыг хангах зорилготой боловч хувийн мэдээллийг нь нийтэд мэдээлэх замаар хүний алдар хүндэд халдсанаар тэнцвэртэй байх зарчим алдагдсан байна.

2.3. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... шударга шүүхээр шүүлгэх...” эрхийг баталгаажуулсан. Иргэн шударга шүүхээр шүүлгэх эрхийн хүрээнд хувийн мэдээлэл халдашгүй байх зэрэг үндсэн эрхийг хуульд заасан үндэслэл, журмаас гадуур, эсхүл дур мэдэн хязгаарласан эсэхийг шүүхээр хянуулж, эрх нь зөрчигдсөн бол сэргээн эдлэх боломжийг хуулиар олгоно. Эрх нь хөндөгдсөн этгээд халдашгүй чөлөөтэй байх эрх нь зөрчигдсөн гэж үзвэл ямар аргаар, хэнд хандаж эрхээ сэргээлгэх боломжтой талаар хуульд тодорхой тусгах шаардлагатай.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “Энэ хууль дараах харилцаанд үйлчлэхгүй:” гээд 3.3.4 дэх заалтад “мэдээллийг нийтэд ил болгохоор хуульд заасан.” гэж зохицуулсан байна. Иймд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу шүүхэд хандах эрхийг хэрэгжүүлэх боломжгүй байна. Гэсэн хэдий ч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж зохицуулсан. Мөн Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн

37.1 дэх хэсэгт “Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно.”, 37.2 дахь хэсэгт “Захирамжилсан үйл ажиллагаа гэж хориглосон, зөвшөөрсөн, журамласан, тогтоосон, эсхүл татгалзсан үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно.” гэсэн байна. Татвар төлөгчийн мэдээллийг түүний зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлэх үйлдэлтэй холбогдуулж Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрх нээлттэй буюу шүүхэд хандах боломжийг олгосон байна.

Дээрхийг нэгтгэн дүгнэвэл Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг нь эрх зүйн үр дагаврын хувьд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх, түүний дотор хувийн мэдээлэл болон алдар хүнд халдашгүй байх эрхийг тус тус хязгаарлаж байгаа тул татвар төлөгчийн хувийн мэдээллийг түүний зөвшөөрөлгүй нийтэд дэлгэх үндэслэл, журам нь тодорхой хуульчлагдсан байх, тохирсон байх, шүүхийн хяналтад байх шалгуурт нийцсэн байх ёстой боловч эдгээрийг бүрэн хангаагүй байна. Тодруулбал, уг зохицуулалтын зарим хэсгийг төрийн эрх бүхий албан тушаалтан дур зоргоор хэрэгжүүлэх, эсхүл огт хэрэгжүүлэхгүй байх боломжтой, түүнчлэн уг заалтыг хэрхэн ойлгон хэрэглэх нь тодорхой бус, мөн хууль ёсны зорилготой нь холбогдуулан авч үзэхэд зайлшгүй, тэнцвэртэй байх шалгуурыг хангаагүй байна.

Иймд Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан ... татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно.” гэж заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ... Иргэний хувийн ... халдашгүй байдлыг хуулиар хамгаална;” гэж заасныг зөрчсөн байна.

Гурав. Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3 дахь заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын холбогдох зохицуулалтыг зөрчсөн эсэх тухайд:

Банк, санхүүгийн байгууллагаас гаргуулж авдаг татвар төлөгчийн дансны мэдээлэл, уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээлэл, дансны гүйлгээний мэдээлэл нь тухайн хүний чөлөөт цагаа өнгөрүүлдэг, худалдан авалт хийдэг орон зай, цаг хугацаа, сонголт зэрэг хүний зан байдал, өдөр тутмын амьдралын хэвшил, дадал зуршил, харилцаа холбооны талаар өргөн хүрээг хамарсан мэдээллийг олж мэдэх нөхцөлийг



бүрдүүлдэг учраас эдгээр нь хүний хувийн мэдээлэлд хамаарна. Дансны болон хүний хөрөнгийн талаарх мэдээлэл нь түүнийг тодорхойлох онцлог шинжийн нэг бүрэлдэхүүн гэж үзэж болно. Тухайлбал, авсан үйлчилгээ, худалдан авалт, хийсэн гүйлгээний утга зэрэг нь тухайн хүний давтагдашгүй онцлог шинжийг шууд болон шууд бусаар илэрхийлэх тул дансны зарлагад дүн шинжилгээ хийснээр түүнийг тодорхойлох, танин мэдэх боломжтой. Иймд банк, санхүүгийн байгууллагад хадгалагдаж буй татвар төлөгчийн дансны мэдээлэл нь хувийн мэдээлэл халдашгүй байх эрхийн хүрээнд хамгаалагдана.

Хувийн мэдээлэл халдашгүй байх эрх нь туйлын эрх биш учраас хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлах боломжтой. Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсэгт “Арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон бусад санхүүгийн эрх бүхий байгууллага дараах мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ.” гээд 34.4.1 дэх заалтад “татвар төлөгчийн дансны мэдээлэл болон уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээллийг татварын албаны шаардсанаар тухай бүр;”, 34.4.3 дахь заалтад “татвар төлөгчийн дансны гүйлгээний мэдээллийг татварын албанаас бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг үндэслэн.” гэсэн нь хувийн мэдээлэл халдашгүй байх эрхэд хуулиар хязгаарлалт тогтоожээ. Тодруулбал, татвар төлөгчийн дансны мэдээлэл, уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээлэл, дансны гүйлгээний мэдээллийг татварын албанд хүргүүлэхээр заасан маргаан бүхий хуулийн зохицуулалт нь иргэний хувийн мэдээллийг гуравдагч этгээд ашиглах боломжийг нээснээрээ Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад заасан халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хүрээнд багтах хувийн мэдээлэл халдашгүй байх эрхийг хязгаарласан шинжтэй байна. Уг үндсэн эрхийн хязгаарлалт нь хуульд тодорхой заасан байх, тохирсон байх, шүүхийн хяналтад байх зэрэг зарчмыг хангасан эсэхийг шалгахад:

3.1.Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хууль дээдлэх ёсны зарчим болон Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын дагуу хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хувийн мэдээлэл (дансны гүйлгээний мэдээлэл зэрэг)-ийг тухайн иргэний хувийн онцлог шинж, зан үйлийг тодорхойлох болон бусад хувийн зорилгоор ашиглах, бусдад дамжуулах зэрэг нь хувийн мэдээлэл халдашгүй байх эрхийн зөрчил болно.

Арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон бусад санхүүгийн эрх бүхий байгууллага нь татварын албанаас татварын хяналт шалгалт, татвар ногдуулалт, хураалт болон татвар төлөгчийн эрсдэл, бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглах, татварын өрийг төлүүлэх чиг үүргээ хэрэгжүүлэхээр хуульд



заасны дагуу шаардлага, хүсэлт ирүүлсэн тохиолдолд зохих журмын дагуу тодорхой харилцагчийн мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй болохыг холбогдох хуулиудад нарийвчлан тусгажээ. Тодруулбал, Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг дор дурдсанаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөх, задруулах, ашиглахыг банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, хянан шалгах зөвлөл, ажилтанд хориглоно.” гээд 7.2.8 дахь заалтад “Гааль, татварын алба тодорхой харилцагчийн гааль, татварын өр төлбөрийг төлүүлэхээр болон татварын хяналт шалгалт хийхээр хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан.” гэж, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт “Банк бус санхүүгийн байгууллага, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд гаргаж өгөх, задлах, ашиглахыг банк бус санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтанд хориглоно.” гэж тус тус хуульчилсан байна. Энэ нь агуулгын хувьд тодорхой буюу хоёрдмол утгагүй, урьдчилан харж өөрийн зан үйлээ нийцүүлж болохуйц байдлаар хуульчилсан гэж үзэхээр байна.

Татварын ерөнхий хуульд татварын алба татвар төлөгчийн талаар хөндлөнгийн мэдээлэл цуглуулж, хөндлөнгийн мэдээллийн санг бүрдүүлж, мэдээллийг татварын хяналт шалгалт, татвар ногдуулалт, хураалт болон татвар төлөгчийн эрсдэл, бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглахаар хуульчилж, 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсэгт заасан байгууллага, албан тушаалтан татварын албанд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх, татварын зорилгоор хамтран ажиллах үүрэг хүлээхээр зохицуулан хувийн мэдээлэл халдашгүй байх үндсэн эрхийг хязгаарлах болсон үндэслэл, зорилгыг хуульд тодорхой тусгасан байна. Тухайлбал, тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт “Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн нууц мэдээллийн санд нэвтрэх эрхтэй татварын улсын байцаагчийг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр томилох бөгөөд түүний нууц мэдээллийн санд нэвтрэх, ашиглах үйлдэл бүртгэлтэй байна.” гэж тусгасан нь эрх бүхий байгууллагад олгосон эрх хэмжээ, түүний цар хүрээ, хэрэгжүүлэх арга хэлбэрийг нарийвчлан тодорхойлж, хуулиас гадуур, дур мэдэн уг эрхэд халдахаас сэргийлсэн байна.

Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.10 дахь заалтад “Татварын зорилгоор мэдээлэл харилцан солилцох талаарх Монгол Улсын олон улсын гэрээний дагуу татварын албаны шаардсан Татварын ерөнхий хуулийн 18.1.2-т заасан мэдээллийг.”, 7.2.8 дахь заалтад “... татварын алба тодорхой харилцагчийн ... татварын өр төлбөрийг төлүүлэхээр болон

татварын хяналт шалгалт хийхээр хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан.” мэдээллийг тус тус гаргаж өгөхөөр тусгажээ. Өөрөөр хэлбэл, татварын албанаас хуульд заасан бүрдүүлбэр ханган ирүүлсэн шаардлага, хүсэлтийг үндэслэн харилцагчийн данстай холбоотой мэдээллийг илгээхээр хуульчилсан. Түүнчлэн холбогдох мэдээллийг төрийн байгууллагад хүргүүлэх урьдач нөхцөл, үндэслэл, шалгуурыг маргаан бүхий зохицуулалтын хүрээнд тодорхой тусгаж, арилжааны банк, хуульд заасан бусад байгууллага нь татвар төлөгчийн дансны мэдээлэл болон уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээллийг татварын албаны шаардсанаар тухай бүр, дансны гүйлгээний мэдээллийг татварын албанаас бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг үндэслэн өгөхөөр тусгайлан журамласан байна.

3.2.Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн шударга ёсны зарчим болон Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын дур мэдэхийг хориглох зарчмын дагуу үндсэн эрхэд хуулиар тогтоосон хязгаарлалт нь тохирсон байх зарчмыг хангасан байна.

3.2.1.Үндсэн эрхийн хязгаарлалт нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журам зэрэг зорилгын үүднээс зөвтгөгдөх боломжтой. Татвар төлөгчийн данстай холбоотой мэдээллийг татварын албанд шилжүүлэх нь Үндсэн хуульд тусгагдсан нийгмийн зайлшгүй хэрэгцээ, ашиг сонирхолд нийцсэн байх бөгөөд үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулах, Монгол Улсын иргэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх, улмаар татварын шударга тогтолцооны үндсэн дээр хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгмийн баталгааг бүрдүүлэх, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх зэрэг Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг, Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад тусгагдсан нийтийн ашиг сонирхлын хууль ёсны зорилгод үйлчлэхээр байна. Тухайлбал, маргаан бүхий хуулийн заалтын зорилго нь Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад заасан “хуулиар ногдуулсан албан татвар төлөх;” иргэний үндсэн үүрэгтэй шууд холбоотой байна. Эрсдэлд суурилсан татварын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, татварын өр хураах, татварын өрийг үл маргах журмаар гаргуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, татвар төлөгчийн талаар хөндлөнгийн мэдээлэл цуглуулах, хөндлөнгийн мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээллийг татварын хяналт шалгалт, татвар ногдуулалт, хураалт болон татвар төлөгчийн эрсдэл, бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор татвар төлөгчийн данс, дансны гүйлгээ болон уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээллийг татварын албанд хүргүүлэхээр хуульд зохицуулжээ.



Монгол Улс нь Татварын зорилгоор ил тод байдал, мэдээлэл солилцооны Олон улсын форумд гишүүнээр элсэн орж, Татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай олон талт конвенцод 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар нэгдэн орсон байна. Энэхүү конвенцоор татварын зорилгоор банк, санхүүгийн байгууллагад байгаа татвар төлөгчдийн мэдээллийг харилцан солилцох дүрэм журам, стандартыг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн байна. Татварын ерөнхий хуулийн маргаан бүхий зохицуулалт нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэхээр заасны дагуу конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх төрийн хууль ёсны зорилгод хамаарч байна.

3.2.2. Үндсэн эрхийн хязгаарлалт нь төрийн хууль ёсны зорилготой, нийгмийн хэрэгцээнд үндэслэсэн, хуулийн зорилго хийгээд авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь уялдаатай байх зарчмын шалгуурыг хангах шаардлагатай. Маргаан бүхий хуулийн заалтын дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ нь уг заалтын зорилгод хүрэхэд чиглэсэн бөгөөд зохистой уялдаатай байна. Тодруулбал, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө.” гэж зохицуулсан. Татвар төлөгч татварын албанд өөрөө бүртгүүлж албан татвараа төлөх, тайлагнах зарчимд суурилдаг татварын тогтолцооны хувьд татвар төлөгч албан татвар төлөх үүргээс зугтаах, татвараас зайлсхийх эрсдэлээс сэргийлэх, татварын хяналт шалгалтын зорилгоор ашиглахаар хөндлөнгийн мэдээллийн сан бүрдүүлэхээр хуульд заасан тул холбогдох байгууллагаас мэдээлэл гаргуулах, хамтран ажиллах замаар хөндлөнгийн мэдээллийг цуглуулж, эрсдэлийн үнэлгээ шинжилгээ хийх, татварын хяналт шалгалтад хамруулж татвар төлөгчийг тогтоох боломжийг тус зохицуулалт бүрдүүлж байна.

3.2.3. Маргаан бүхий хуулийн зохицуулалт нь зайлшгүй байх шалгуурт нийцсэн байна. Өөрөөр хэлбэл, уг зохицуулалт үндсэн эрхийг хэт өргөн хүрээнд хязгаарласан, эсхүл хуулийн хэрэгжилтийг хэн нэгэн албан тушаалтны дур зоргод үлдээсэн гэх үндэслэл тогтоогдохгүй байна. Халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хүрээнд хувийн мэдээлэл нь найдвартай хамгаалалтад байгаа гэсэн хувь хүний үндэслэл бүхий хүлээлтийг хамгаална. Энэ хүрээнд татвар төлөгчийн холбогдох мэдээллийг нийгмийн хэрэгцээний зорилгоос гадуур ашиглахаас сэргийлэх хэм хэмжээг хуульд тусгажээ. Тухайлбал, татвар төлөгчийн хувийн амьдрал, дадал зуршил, сонголтын талаар өгөгдөл бүхий дансны гүйлгээний мэдээллийг тухай бүр зөвхөн татварын албанаас бичгээр болон цахимаар гаргасан хүсэлтийг үндэслэн хүргүүлэхээр зохицуулсан нь хувийн мэдээлэл халдашгүй байх эрхийг хамгийн багаар хязгаарлах буюу зорилгодоо хүрэхэд шаардлагатайгаас илүү хязгаарлахгүй байх зарчимд нийцсэн байна.

Татвар төлөгчийн орон байр, бизнесийн байр руу нэвтэрч оролгүйгээр зөвхөн дансны холбогдох мэдээллийг шаарддаг учраас татвар төлөгчийн дансны мэдээллийг авах нь татварын хяналт, шалгалт хийх бусад аргатай харьцуулахад хувийн мэдээлэл халдашгүй байх эрхийг зохистой хэмжээнд хязгаарласан байна.

Татвар төлөгчийн мэдээллийг хуулийн зохицуулалтын зорилгоос гадуур ашиглах боломжийг хязгаарлах үүргийг төр хүлээнэ. Энэ хүрээнд Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлд татвар төлөгчийн мэдээллийг бусдад өгөх (задруулах), эсхүл хувийн зорилгоор ашиглахыг хориглож, зөвхөн татварын зорилгоор ашиглах, олон улсын гэрээ болон хуульд зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй байх, нийтэд дэлгэхгүй байх зэрэг татвар төлөгчийн хууль ёсны эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэсэн зохицуулалтыг хууль тогтоомжид тусгаж, мэдээллийн санд нэвтрэх эрхтэй татварын байцаагчийн томилгооны ерөнхий журмыг нарийвчлан тогтоож, мэдээллийн санд нэвтрэх, ашиглах үйлдэл бүртгэлтэй байх зэргээр татвар төлөгчийн мэдээллийг дур мэдэн, урвуулан ашиглахаас сэргийлж, хуулийн хамгаалалт тогтоосон байна.

Мөн албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн татвар төлөгчийн мэдээллийн нууцыг хадгалахаар үүрэгжүүлж, Татварын ерөнхий хуулийн 85 дугаар зүйлд татварын улсын байцаагч, хураагчийн үйлдсэн татварын хууль тогтоомжоор хамгаалагдсан татвар төлөгчийн мэдээллийн нууцыг задруулсан, тус хуульд заасан албан тушаалын эрхээ хэтрүүлсэн, эсхүл үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй зөрчилд холбогдуулж Захиргааны ерөнхий хуулийн 105, 106, 107 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэх, улмаар эдгээр зөрчлийн улмаас татвар төлөгчид хохирол учруулсан бол уг хохирлыг гэм буруутай албан хаагч хариуцахаар заасан байна.

3.2.4. Хувийн мэдээлэл халдашгүй байх эрхийн хамгаалалтын хүрээ, хязгаар нь мэдээллийн онцлогоос хамаарч харилцан адилгүй байна. Тиймээс энэ эрхийг хязгаарлах үндэслэл, хязгаарлалтын цар хүрээ, үүсэж болзошгүй хор урсиг, үр дагавар нь Үндсэн хуулиар хамгаалагдсан бусад ашиг сонирхолтой явцуу утгаараа тэнцвэртэй байгаа тохиолдолд уг эрхийн хязгаарлалт зөвтөгдөх боломжтой юм.

Татвар төлөгчийн дансны мэдээлэл, уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээлэл, дансны гүйлгээний мэдээллийг банк, санхүүгийн байгууллагаас дээр дурдсан үндэслэл, журмаар гаргуулж авснаар хангагдах нийтийн ашиг сонирхол нь энэ тохиолдолд хувийн мэдээлэл халдашгүй байх эрхийн хамгаалалтаас илүү ач холбогдолтой байх тул Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3 дахь заалт нь тэнцвэрийн зарчмыг хангаж байна. Тодруулбал, маргаан бүхий хуулийн зохицуулалт нь хуулиар ногдуулсан албан татвар төлөх

Үндсэн хуулиар тогтоосон иргэний үндсэн үүргийг хэрэгжүүлэх, татварын хяналт шалгалт хийх, эрсдэлийг үнэлэх, шинжлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд улсын төсөвт төвлөрөх татварын орлогыг нэмэгдүүлэхэд бодитой үр нөлөөтэй байна.

Мөн хувийн мэдээлэл халдашгүй байх эрхийн уг хязгаарлалт нь хувийн амьдралаа хэвийн явуулах, хувийн орон зайндаа эрх чөлөөгөө эдлэхэд нь шууд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсгээгүй байна.

3.3.Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад туссан шударга шүүхээр шүүлгэх эрхийн хүрээнд хувийн мэдээлэл халдашгүй байх эрх нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхээр даруй хянуулах эрхтэй. Татварын ерөнхий хуулийн 76 дугаар зүйлд татварын албаны үйл ажиллагааны зарчим, эрх үүрэг, хориглох зүйлийг тусгасан байх бөгөөд тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6, 12.1.9 дэх заалт, 81 дүгээр зүйлд татварын албаны шийдвэр, үйл ажиллагаанд холбогдох гомдлоо татвар төлөгч харьяаллын дагуу хандаж шийдвэрлүүлэх, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй талаар тусгасан байна. Мөн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасны дагуу Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлэх эрх нь нээлттэй байна.

Дээр дурдсан үндэслэлүүдээс үзэхэд Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3 дахь заалт нь хууль дээдлэх ёсны хүрээнд тогтоосон шалгуурт нийцсэн байх бөгөөд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

4.Иргэдийн мэдээллийн шаардлагад тусгасан Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын "... нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, ... Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. ..." гэсэн нь Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3 дахь заалттай агуулга, учир зүйн хамааралгүй байх тул Үндсэн хуулийн цэц энэ хүрээнд дүгнэлт гаргах үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1.Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт "Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль



тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан ... татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ... Иргэний хувийн ... халдашгүй байдлыг хуулиар хамгаална,” гэж заасныг зөрчсөн байна.

2.Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1 дэх заалтад “татвар төлөгчийн дансны мэдээлэл болон уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээллийг татварын албаны шаардсанаар тухай бүр;”, 34.4.3 дахь заалтад “татвар төлөгчийн дансны гүйлгээний мэдээллийг татварын албанаас бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг үндэслэн.” гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;” гэж заасныг зөрчөөгүй байна.

3.Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан ...” гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**ГИШҮҮД**

**Г.БАЯСГАЛАН**

**Ж.ЭРДЭНЭБУЛГАН**

**Д.ГАНГАБААТАР**

**О.МӨНХСАЙХАН**

**Э.ЭНХТУЯА**

























































































